Асаргааны тусгай ур чадварын үнэлгээний шалгалт

Сургалтын материал

～Асаргааны ур чадвар
ба асаргааны япон хэл～

Монгол хувилбар

Японы Мэргэшсэн Асрагчдын Нийгэмлэг НҮТББ
2024 он 3 сар

はじめに

本書は、厚生労働省の補助事業（介護の日本語学習支援等事業）を活用して、介護分野の特定技能１号の評価試験に対応する初めての学習用テキストとして策定したものです。

2019 年４月に施行された在留資格「特定技能」の制度は、深刻化する人手不足に対応するため、生産性向上や国内人材の確保のための取組を行ってもなお人材を確保することが困難な状況にある産業上の分野において、一定の専門性・技能を有する外国人材を受け入れる制度です。

介護分野において特定技能の在留資格で入国するためには、国際交流基金が実施する日本語基礎テスト等の日本語試験のほか、厚生労働省が実施する介護技能評価試験と介護日本語評価試験を受験し、合格することが基本となります。

今後、試験の実施国は拡大されていく予定ですので、介護分野で特定技能により入国される方は、さらに増えていくことが見込まれます。そこで本書は、介護技能評価試験と介護日本語評価試験に対応できるようにしつつ、介護現場で働く上で、最初に習得しておいていただきたい内容を中心に作成いたしました。

本書は、介護技能評価試験と介護日本語評価試験の受験対策として活用されることに加え、特定技能の在留資格で入国して介護現場で働かれる皆様が、引き続き本書を手元に置き、ご活用いただけるような構成にしています。

本書が、「日本の介護」を知る契機となり、その魅力を存分に感じていただくものになること、さらに、介護分野の特定技能により入国して介護現場でご活躍いただく際の一助となることを切に願っております。

公益社団法人 日本介護福祉士会
特定技能評価試験対応テキスト検討会

Энэхүү номыг ашиглах заавар

“Асаргааны тусгай ур чадварын үнэлгээний шалгалт” Сургалтын материал ~Асаргааны ур чадвар ба асаргааны япон хэл~” нь асаргааны ур чадварын үнэлгээний шалгалт болон асаргааны япон хэлний ур салбарын тусгай ур чадварын үнэлгээний шалгалтад зориулсан сургалтын материал юм.

- Энэ ном нь асаргааны салбар дахь тусгай ур чадварын үнэлгээний шалгалтын шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн “Асаргааны ур чадвар” болон “Асаргааны япон хэл”-с бүрдсэн.
- Асаргааны япон хэлний үнэлгээний шалгалтыг япон хэлээр авах тул “Асаргааны япон хэл” хэсгийг орчуулан хөрвүүлэхгүй ба, зөвхөн япон хэл ашиглах болно.

“Асаргааны ур чадвар” нь шалгалтын асуултуудад тааруулсан дараах 4 хэсгээс бүрдэнэ.

БҮЛЭГ 1 Асаргааны үндэс
БҮЛЭГ 2 Бие ба сэтгэлийн бүтэц
БҮЛЭГ 3 Харилцааны арга техник
БҮЛЭГ 4 Амьдралыг тэтгэх арга техник

⦿ Асаргааны талбар дээр ажиллаж байсан туршлага байхгүй байсан ч төсөөлөл авахад хялбар болгож зураг дүрслэл олноор оруулсан.

⦿ Ялангуяа гол чухал зүйлсийг дүрслэлтэйгээр харуулсан.

⦿ Хүндэвтэр мэргэжлийн хэллэгүүдэд тайлбар оруулж өгсөн.

Бүх биеэ ашиглавал хялбархан хөдлөх боломжтой.

Тайлбар

Дэмжлэгийн суурь талбай

Биеийг тулж өргөж байх үүднээс шалтай тулж байгаа хэсгүүдийг холбосон зурвас талбай. Хоёр хөлөө салган зогсож байх үед хоёр хөлийн улны гадна хэсгээр хүрээлсэн талбай.

“Асаргааны япон хэл” нь даалгавруудыг ажиллах замаар япон хэлний мэдлэгийг гүнзгийрүүлэх боломжтой болсон.

Асаргааны япон хэлний үнэлгээний шалгалт нь жинхэнэ асаргааны талбар дээр ашиглагдах япон хэлийг сурч эзэмшсэн эсэхийг шалгах агуулгатай байдаг. Асаргааны талбар дээр ажиллахын тулд шаардлагатай япон хэлийг сурч эзэмшихийн тулд Японы олон улсын хамтын ажиллагааны сангийн япон хэлний суурь шалгалт (JFT-Basic) болон япон хэлний ур чадварын шалгалтын сургалттай хамтатгасны нөлөөгөөр асаргааны япон хэлний сургалт нь илүү үр дүнтэй болдог.

- Шалгалтын асуултуудад тааруулан асаргааны ажилд ихээр ашиглагдах “Үг” (үгсийн сан), “Харилцан яриа, дуудлага” (даалгавар), “Текст” (даалгавар)-с бүрдсэн байдаг.

- “Харилцан яриа, дуудлага” “Текст” нь асаргааны талбар дээр илүү их ашиглагдах илэрхийллийг ашиглан даалгавар асуулт боловсруулж байна.

Гарчиг

はじめに 1

Энэхүү номыг ашиглах заавар 2

Асаргааны ур чадвар

бүлэг 1 Асаргааны үндэс

хэсэг 1 Асаргаа дахь хүн хоорондын хүндлэл болон бие даасан байдал 10

хэсэг 2 Асрагчийн үүрэг, ажил мэргэжлийн ёс зүй 16

хэсэг 3 Асаргаа дахь аюулгүй байдлын хангалт ба эрсдэлийн удирдлага 24

бүлэг 2 Бие ба сэтгэлийн бүтэц

хэсэг 1 Бие болон сэтгэлийн бүтцийн ойлголт 42

хэсэг 2 Асаргаа шаардлагатай хүний тухай ойлголт 68

—— Хөгшрөлтийн тухай үндсэн ойлголт

—— Хөгжлийн бэрхшээлийн тухай үндсэн ойлголт

—— Тэнэгрэлийн тухай үндсэн ойлголт

бүлэг 3 Харилцааны ур чадвар

хэсэг 1 Харилцааны үндэс 98
хэсэг 2 Асруулагчтай харилцах харилцаа 102
хэсэг 3 Багийн харилцаа 114

бүлэг 4 Амьдралыг тэтгэх арга техник

хэсэг 1 Хөдөлгөөний асаргаа 120
хэсэг 2 Хооллох асаргаа 144
хэсэг 3 Бие засах асаргаа 152
хэсэг 4 Бие арчлах асаргаа 170
хэсэг 5 Усанд орох, ариун цэвэр сахих асаргаа 186
хэсэг 6 Гэрийн ажлын асаргаа 198

Асаргааны япон хэл

Үг цээжилье!

Бие 204

Биеийн байрлал 206

Өвчин, зовиур 207

Хөдөлгөөний асаргаа

Үг 208

Даалгавар (Харилцан яриа, дуудлага) 209

Хооллох асаргаа

Үг 213

Даалгавар (Харилцан яриа, дуудлага) 215

Бие засах асаргаа

Үг 219

Даалгавар (Харилцан яриа, дуудлага) 220

Бие арчлах асаргаа

Үг 224

Даалгавар (Харилцан яриа, дуудлага) 225

Усанд орох, ариун цэвэр сахих асаргаа

Үг 230

Даалгавар (Харилцан яриа, дуудлага) 231

Гэрийн ажлын асаргаа

Үг 238

Даалгавар (Харилцан яриа, дуудлага) 239

Текст

Үг 245

Даалгавар (Текст) 247

Хариулт хэсэг

Даалгаврын хариулт “Харилцан яриа, дуудлага” “Текст” 271

Хариултын хуудас 272

Япон хэл сурах цахим контент

“Nihongo o Manabou” танилцуулга

БҮЛЭГ 1

Асаргааны үндэс

хэсэг 1 Асаргаа дахь хүн хоорондын хүндлэл болон бие даасан байдал

хэсэг 2 Асрагчийн үүрэг, ажил мэргэжлийн ёс зүй

хэсэг 3 Асаргаа дахь аюулгүй байдлын хангалт ба эрсдэлийн удирдлага

1 Асаргаа дахь хүн хоорондын хүндлэл болон бие даасан байдал

1 Хүндлэлийг дэмжих асаргаа

1) Хүн хоорондын хүндлэл болон хүний эрхийг дээдлэх

- Асрагч нь өндөр нас болон хөгжлийн бэрхшээлийн улмаас өдөр тутмын амьдралд нь саад бэрхшээл тулгарсан хүн, түүний хүн ёсны амьдралыг үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ажилтан юм.
- Дэмжлэг үзүүлэх суурь ойлголт бол хүн хоорондын хүндлэл юм.
- Хүн хоорондын хүндлэл гэдэг нь хүн нэг бүрчлэн хувь хүн гэх үүднээс хандан дээдлэх явдал юм.
- Асаргаа шаардлагатай болсон ч хүн төрөлхтний нэг гэх үүднээс хүндлэгдэн, хүний эрх хамгаалагдана.

2) Амьдралыг асруулагч төвтэйгээр

- Амьдрал нь амьдарч буй хүний ухамсар, дадал зэргээр, хүн нэг бүрчлэн өөр өөр байдаг. Асаргаа шаардлагатай ч амьдралын эзэн нь асруулагч өөрөө.
- Яаж амьдармаар байгаа, амьдрах арга хэлбэр болон үзэл бодлыг хүндэтгэж, түүний хүн ёсны амьдралаар амьдарч чадах хэмжээнд дэмжлэг үзүүлэх нь асаргааны үндсэн ойлголт.

Төрөл бүрийн амьдралын хэв маяг

3) QOL (Quality of life: Амьдралын чанар)

- Амьдралын чанар нь хүний амьдралын чанар болон амь насны чанар ч гэж яригддаг. QOL нь хүний амьдрал дахь сэтгэл ханамж болон аз жаргал, амьдралын утга учир зэрэг сэтгэлийн баян чинээлэг байдлыг багтаах амьдралын тухай ойлголт юм.

4) Хэвийн байдал (Эрх тэгш байдал)

- Хэвийн байдал (Эрх тэгш байдал) гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ч гэсэн хөгжлийн бэрхшээлгүй хүнтэй адилаар өөр өнцгөөс харагдалгүйгээр хүний эрхээ хамгаалуулж, энгийнээр амьдрах боломжтой байх гэсэн ухагдахуун юм.
- Нийгэм болон бүс нутаг дунд тэрхүү хүн ёсны бөгөөд тэсэн тэвчих зүйлгүйгээр, энгийнээр амьдрах явдал юм.

2 Бие даах дэмжлэг

1) Бие даахыг дэмжих

- Бие даах дэмжлэг гэдэг нь асруулагч өөрөө хэрхэн амьдрахаа сонгож, өөрөө шийдвэр гаргаж, өөрийн дураар амьдрахыг дэмжих дэмжлэг юм.
  Хөдөлгөөн болон хувцас солих зэрэг бие эрхтний үйлдэл хөдөлгөөн төдийгүй, тухайн хүнд байгаа чадварт нийцсэн дэмжлэгийг үзүүлдэг.
- Асруулагчийн үнэт зүйл болон өвөрмөц байдлыг чухалчлан, хувь хүний санал болон өөрийн хүчээр хийж чадах зүйлийг нэмэгдүүлж, амжилтын мэдрэмж төрүүлэхийн төлөө дэмжлэг үзүүлнэ.

2) Өөрийн сонголт ба өөрийн шийдвэр

- Амьдралын эзэн нь асруулагч өөрөө. Өнөөг хүртэлх амьдарч ирсэн арга болон үнэт зүйлд нь тулгуурлан өөрөө хэрхэх тухайгаа шийдэж явах.
- Бие даахад бие эрхтний бие даалт болон сэтгэлийн бие даалт гэж байдаг. Асаргаа хэрэгтэй байсан ч өөрийн дураар амьдрах боломжтой байхаар амьдрах хэв маяг болон аргыг өөрөө сонгон шийдвэрлэнэ.



3 Амьдралын ойлголт

1) Амьдрал гэдэг нь

- Амьдралд тухайн улсаас хамааран соёл болон зан заншлын ялгаа байдаг. Хувь хүний бодол, үнэт зүйл болон онцлогоос хамааран төрөл бүрийн амьдралын хэлбэр байдаг.
- Өглөө орноосоо босох, хувцсаа өмсөх, нүүрээ угаах, цайгаа уух, бие засах, усанд орох, чөлөөт цаг, орой унтах гэх амьдралын хэмнэл байдаг.



- Амьдрахын тулд хувь хүний эрүүл мэндийн байдал болон орон байр, гэрийн ажил хийх чадвар, гэр бүл, бүс нутаг, нийгэм зэрэг ч холбогдоно.

2) Асаргааны ажлаар хийх амьдралын дэмжлэг

- Асруулагчийн амьдрах аргыг бүрэн дүүрэн ойлгож асаргаа хийх нь тухайн хүний хүн ёсны амьдралыг дэмжинэ.
- Асаргаа шаардлагатай болоход бодол санаа болон үйл хөдлөл нь идэвхгүй болохдоо хялбар байдаг. Асаргааны ажил нь асруулагчийн хүсэл сонирхлыг идэвхжүүлнэ.

2 Асрагчийн үүрэг, ажил мэргэжлийн ёс зүй

1 Асаргааны ажлын ажил мэргэжлийн ёс зүй

1) Хувийн нууцад тавих анхаарал

- Усанд оруулах болон бие засуулах тохиолдолд асруулагчийн нүцгэлэх болдог. Асрагч нь асруулагчийг ичээхгүйн тулд хувийн нууцад анхаарал тавих нь чухал юм.

2) Нууцыг хадгалах

- Асрагч нь асруулагчид зохих асаргааг үзүүлэхийн тулд асруулагчтай холбоотой мэдээллийг мэдэх шаардлага гардаг. Гэвч, асрагч нь асруулагчтай холбоотой хувийн мэдээлэл (хувь хүний мэдээлэл) (нас, гэрийн хаяг, өвчний түүх зэрэг)-г дурааараа бусдад ярьж болохгүй.
- Интернет болон сошиал сүлжээ зэргээр асруулагчийн зөвшөөрлийг авалгүйгээр асруулагчтай холбоотой мэдээллийг илгээж болохгүй.

3) Биеийн эрх чөлөөг хязгаарлахыг хориглох

- Биеийн эрх чөлөөг хязгаарлах гэдэг нь асруулагчийн биеийн чөлөөт байдлыг хориглох явдал юм.

⦿ Биеийн эрх чөлөөг хязгаарлахын хор нөлөө

Биеийн эрх чөлөөг хязгаарлах нь асруулагчийн биеийн чадавхыг бууруулж, тэнэгрэлд муугаар нөлөөлөх зэрэг хорт нөлөө бий болгодог.

● Биеийн эрх чөлөөг хязгаарлах үйлдлийн жишээ

(1) Бие болон гар хөлийг уяагаар хүлж, хөдөлгөөнгүй болгох.

(2) Орыг хашлагаар хүрээлж, өөрөө орноосоо бууж чадахгүй болгох.



(3) Өрөөг цоожлон түгжих.

(4) Хязгаарлах бүс зүүж босох боломжгүй болгох.

(5) Сэтгэцэд нөлөөлөх эм их хэмжээгээр уулгах.



4) Хүчирхийлэл

- Хүчирхийлэл гэдэг нь асруулагчийн хүний эрхийг зөрчих явдал юм.

Хүчирхийллийн 5 төрөл

(1) Биеийн хүчний хүчирхийлэл
Асруулагчийн биед халдан довтлохыг хэлнэ.

(2) Сэтгэл санааны хүчирхийлэл
Асруулагчид сэтгэл санааны шарх сорви үүсгэх үйл хөдлөлийг хэлнэ.

(3) Асаргаа зэргээс татгалзах (үл хайхрах)
Асаргаа шаардлагатай хүнийг үл тоохыг хэлнэ.

(4) Эдийн засгийн хүчирхийлэл
Асруулагчийн өмч хөрөнгийг шударга бус аргаар олж авахыг хэлнэ.

(5) Бэлгийн хүчирхийлэл
Асруулагчид ёс зүйгүй үйлдэл хийхийг хэлнэ.

2 Мэргэжлийн олон талт хамтын ажиллагаа

1) Багийн хандлага

- Асрагчаас гадна төрөл бүрийн мэргэжилтнүүд нь тус бүрийн мэргэжлийн онцлогийг гарган, асруулагчид багаар үйлчилдэг.



2) Бусад төрлийн мэргэжилтний гүйцэтгэх үүрэг ба үйл ажиллагаа

(Эмчилгээний үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэн)

Эмчилгээний үйл ажиллагаа нь анагаах ухааны мэдлэг, технологид тулгуурлан хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Асрагч нь зарчмын хувьд эмчилгээний үйл ажиллагаа явуулж болохгүй. Эмчилгээний үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэн нь эмч болон сувилагч юм.

● Эмч

Өвчний оношилгоо болон эмчилгээг хийдэг.

● Сувилагч

Эмчийн зааврын дагуу сувилахуйн асаргаа болон эмчилгээний тусламжийг хийдэг.

(Нөхөн сэргээлт хийх мэргэжилтэн)

Үйл ажиллагааг сэргээн засах дасгал зэргийг хийлгэдэг мэргэжилтнээр хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл, сонсгол засалч ажилладаг.

● Хөдөлгөөн засалч (PT)

Алхах зэргийн хөдөлгөөний чадварыг сайжруулах дасгал хийлгэдэг.

● Хөдөлмөр засалч (OT)

Өдөр тутмын амьдралд шаардлагатай үйл ажиллагааны дасгал хийлгэдэг.

● Хэл, сонсгол засалч (ST)

Ярих болон залгих (залгин гулгуулах) нь хүндрэлтэй асруулагчид дасгал хийлгэдэг.

(Хооллохтой холбоотой мэргэжилтэн)

Өвчний улмаас хооллох хэлбэр болон илчлэг зэргийг анхаарахгүй болон болохгүй асруулагч байдаг. Хооллохтой холбоотой мэргэжилтнээр эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас итгэмжлэгдсэн хоол зүйч байдаг.

- **Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас итгэмжлэгдсэн хоол зүйч эмч**

Шим тэжээлийн тэнцвэрийг бодолцсон цэс боловсруулна.

(Халамжийн үйлчилгээний тухай зөвлөгөө, тохируулга гүйцэтгэх мэргэжилтэн)

Асруулагч нь халамжийн үйлчилгээ зэргийг ашиглахтай холбоотойгоор үйлчилгээний зөвлөгөө, тохируулга хэрэгжүүлэх мэргэжилтнээр асаргаа дэмжлэгийн мэргэжилтэн болон нийгмийн ажилтан нь дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулдаг.

- **Асаргаа дэмжлэгийн мэргэжилтэн (Асаргааны менежер)**
- **Нийгмийн ажилтан (Нийгмийн халамжийн мэргэжилтэн зэрэг)**

Асруулагчаас зөвлөгөө болон гэр бүлтэй нь холбоо барих, зохицуулалт хийдэг.

3 Асаргааны үйлчилгээ

1) Асаргааны үйлчилгээний тойм

Асаргааны үйлчилгээнд олон янзын төрөл байдаг.

(1) Гэрээр үйлчлэх үйлчилгээ

- Асруулагчийн гэрт нь зочлон, асруулагчид үйлчилдэг.
- Гэрийн асаргаа (гэрийн туслах үйлчилгээ) зэргийн үйлчилгээ байдаг

(2) Өдөр өнжүүлэх үйлчилгээ

- Өдрийн цагаар, асрамжийн газар асруулагчид үйлчлэх үйлчилгээ байдаг.
- Өдөр өнжүүлэх асаргаа (өдрийн үйлчилгээ) зэрэг үйлчилгээ байдаг.

(3) Асрамжийн газар байрлах үйлчилгээ

- Асрамжийн газарт асруулагчид үйлчилгээ үзүүлдэг.
- Өндөр настны асрамж халамжийн газар (Ахмадын тусгай асрамжийн газар) зэргийн үйлчилгээ байдаг.

(1) Гэрээр үйлчлэх үйлчилгээ



Гэрийн туслах үйлчилгээ зэрэг

Гэр

(2) Өдөр өнжүүлэх үйлчилгээ



Гэр

Өдрийн үйлчилгээ зэрэг

(3) Асрамжийн газар байрлах үйлчилгээ

Ахмадын тусгай асрамжийн газар зэрэг

2) Асаргааны шат дараалал

- Асрагч нь асруулагчийн бие даахад нь дэмжихийг зорилго болгон төлөвлөгөөний дагуу асаргаа хийнэ.
- Асаргааны шат дараалалд асруулагч нэг бүрчлэн асаргааны төлөвлөгөө боловсруулна.

Асаргааны шат дараллын үндсэн урсгал

(1) Асуулга

Асруулагчтай холбоотой мэдээлэл цуглуулан, амьдралын асуудал зэрэгт шинжилгээ хийнэ.

(2) Төлөвлөгөө боловсруулах

Асруулагчид үзүүлэх асаргааны төлөвлөгөөний агуулгыг боловсруулна.

(3) Хэрэгжүүлэх

Асруулагчид асаргааны төлөвлөгөөнд тулгуурласан асаргааг хийнэ.

(4) Үнэлэх



Асаргааны төлөвлөгөөний агуулга нь асруулагчид тохирч байгаа эсэхийг үнэлнэ.

3 Асаргаа дахь аюулгүй байдлын хангалт ба эрсдэлийн удирдлага

1 Асаргаа дахь аюулгүй байдлын хангалт

1) Ажиглалтын ач холбогдол

⦿ Ажиглалт гэдэг нь

Асруулагчийн байр байдлыг мэдэхийн тулд маш анхааралтайгаар харах явдал юм.

⦿ Ажиглахын ач холбогдол

Асрагч нь ажигласан байх нь асруулагчийн амьдрал сайжрахад нөлөөлнө.

Ажигласан зүйлээ тэмдэглэж, бүх ажилчдад мэдэгдэнэ.

⦿ Ажиглах арга

(1) Асруулагчтай харьцсанаар олж авах боломжтой мэдээлэл байдаг.

(2) Хэмжилт зэргээр олж авах боломжтой мэдээлэл байдаг.

2) Асрагчийн өөрийн эрүүл мэндийн хяналт

⦿ Асрагчийн эрүүл мэндийн хяналтын ач холбогдол

Асрагч нь өөрийн эрүүл мэндийг хамгаалж байх хэрэгтэй. Асрагч нь өөрөө эрүүл биш байвал илүү сайн асаргаа үзүүлж чадахгүй.

⦿ Эрүүл мэндээ хамгаалахын тулд шаардлагатай зүйлс (Нурууны өвдөлтөөс сэргийлэх)

Асрагч нурууны өвдөлт болох нь амархан байдаг тул анхаарах хэрэгтэй. Нурууны өвдөлтөөс зөв мэдлэг болон дадлаар сэргийлэх боломжтой.

Байрлал болон нурууны өвдөлт



Биеийн механикийн хэрэглээ нь нурууны өвдөлтөөс сэргийлнэ.



Ууц нуруунд ачаалал өгөхөд амархан болдог.

3) Биеийн механикийн үндсэн зарчмын хэрэглээ

- Хөдөлгөөний асаргаа хийх тохиолдолд асруулагчийн аюулгүй байдал болон асрагчид ирэх ачааллыг багасгах шаардлагатай болдог.
- Биеийн механик гэдэг нь араг яс болон булчингийн харилцан хамаарлаар бий болох биеийн хөдөлгөөний бүтцийг хэлнэ. Биеийн механикийн үндсэн зарчмын хэрэглээгээр бага хүчээр аюулгүй асаргаа хийх боломжтой.

(1) Дэмжлэгийн суурь талбайг томсгож, хүндийн төвийг доошлуулна.



Таяг тулснаар дэмжлэгийн суурь талбай томорч, илүү тогтвортой болно.

Тайлбар

Дэмжлэгийн суурь талбай

Биеийг тулж өргөж байх үүднээс шалтай тулж байгаа хэсгүүдийг холбосон зурвас талбай. Хоёр хөлөө салган зогсож байх үед хоёр хөлийн улны гадна хэсгээр хүрээлсэн талбай болно.

(2) Асаргаа хийх талын талд хүндийн төвийг ойртуулна.



Ойрхон байх тусам бага хүчээр асаргаа хийх боломжтой.

(3) Бүдүүн гуя зэрэг илүү том булчинг ашиглана.



Шилбэ болон хонгоны том булчинг ашиглаж байна.

Өвдөгний үе тэнийсэн хэвээр зөвхөн нурууны булчингаар өргөж байна.

Том булчин ашигласнаар хялбархнаар асаргаа хийх боломжтой.

(4) Асруулагчийн биеийг хумьж багасгана.



(5) “Түлхэх”-с илүү “Өөр лүүгээ” татна.



(6) Хүндийн төвийн шилжилтийг аль болох хэвтээ чигт хийх.

(7) Биеийг эргүүлэлгүйгээр хөлийн үзүүрийг хөдөлгөх чигт чиглүүлнэ.



(8) Хөшүүргийн дүрмийг ашиглана.



⦿ Нурууны өвдөлтөөс сэргийлэх гол санаанууд

- Асруулагчийн чадавхыг ашиглах: Асруулагчийн байр байдлыг шалгаж, асруулагчийн хүчийг ашиглана.
- Асрамжийн багаж хэрэгсэл ашиглах: Өргөгч болон гулсдаг тавцан зэргийг ашиглана.
- Биеийн механикийн хэрэглээ
- Амьдралын хэв маягийг өөрчлөх: Тохирох хэмжээний хөдөлгөөн, шим тэжээл, амралт нь маш чухал.



Өргөх төхөөрөмж

Гулсдаг тавцан

⦿ Сэтгэцийн эрүүл мэндийн хяналт

Асаргааны ажлыг тогтвортой хийхийн тулд асрагч нь өөрийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах шаардлагатай. Түгшүүр болон санаа зовоох зүйлийг ганцаараа тээж явахгүй байх хэрэгтэй.

Зарчимч амьдралаар амьдрах нь сэтгэц болон биеийн эрүүл мэндэд хэрэгтэй.

● Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах арга



Хооллох цаг болон унтах цагийг баримтлах.

Өөрт тохирсон стресс тайлах аргыг олж мэдэх.

Ахмад ажилтан болон найзтайгаа ярилцах, зөвлөх.

4) Халдварт өвчин болон авах арга хэмжээ

⦿ Халдварт өвчний тухай үндсэн мэдлэг

Халдварт өвчин гэдэг нь өвчин үүсгэгч зэрэг нь биед орж, төрөл бүрийн шинж тэмдэг бий болгох өвчнийг хэлнэ.

Асруулагч нь эсэргүүцэл муу байдаг. Нийтээр амьдарч байхад халдварт өвчин амархан тусдаг.

Асрагч бүр халдварт өвчний тухай мэдлэгтэй байх шаардлагатай.

Эсэргүүцэл муудвал халдварт өвчин тусахдаа амархан.



Эрүүл үед халдварт өвчин амархан тусдаггүй.

⦿ Өвчин үүсгэгчийн төрөл

Өвчний учир шалтгаан болох зүйл нь вирус, нян, мөөгөнцөр, паразит зэрэг байдаг.

⦿ Ажиглан харах зүйл

Халдварт өвчнөөс сэргийлэхэд асруулагчийг ажиглах нь маш чухал. Ажиглах зүйлсийн хувьд, халуурах, бөөлжих, гүйлгэх, гэдэс өвдөх, туурах, цонхийх зэрэг шинж тэмдэг илэрвэл, эмчид мэдэгдэх нь чухал.

⦿ Халдварт өвчний 3 элемент, арга хэмжээний зарчим

Халдварт өвчний 3 элемент нь халдварын голомт, халдварын зам, халдварын тээгч юм. Халдварт өвчин нь 3 элемент холбогдон бүрэлдсэн цагт тусдаг.

Халдвараас сэргийлэх зарчим нь гинжин хэлхээг таслах явдал юм. Халдварын гинжин хэлхээг таслах нь (1) халдварын голомтыг арилгах, (2) халдварын замыг таслах, (3) халдварын тээгч (хүн)-ийн биеийн дархлааг дээшлүүлэх юм.

● Халдварт өвчний 3 элемент, таслах зарчим



Халдварыг зогсоох үндсэн зарчим болох дараах 3 зүйл байдаг.

(1) Оруулахгүй

(2) Гаргахгүй

(3) Тархаахгүй

● Халдварын замын төрөл

Халдварын голомтын төрөл

Цус

Биеийн шингэн (Шүлс, нус зэрэг)

Ялгадас (бөөлжис, шээс, өтгөн зэрэг)

⦿ Стандарт сэргийлэх арга хэмжээ (Standard, Precaution)

Үндсэн ойлголт нь “Бүх өвчтөний цус, биеийн шингэн, даавар, ялгадас, шарх, арьс, салст бүрхэвч зэрэг нь халдвар авах эрсдэлтэй зүйл гэж авч үзэхгүй бол болохгүй” гэх зүйл.

Цус, биеийн шингэн, ялгадас зэрэгт нүцгэн гараар хүрч болохгүй. Заавал бээлий өмсөж асаргаа хийнэ.

Ашиглах зүйлсийн жишээ

Бээлий

Гялгар хормогч

Маск



Бээлий өмссөн байсан ч гарыг угаах.

Маск зөв зүүх арга



Хамарнаас эрүү хүртэл бүрхэнэ.

⦿ Нэг удаагийн бээлийг солих арга

- Бохирдсон хэсгийг дотор талд нь оруулж хаяна.
- Заасан газар хаяна.
- Удаа дараа солино.

⦿ Гар угаах арга болон анхаарах зүйл

Гар угаах нь гоожуурын ус болон шингэн савангаас бүрдэх ба спирттэй гар ариутгах шингэн байх тохиолдол бий.

Амархан бохирддог хэсэг



■ Гар угаахад хамгийн их орхигддог хэсэг
■ Гар угаахад сайтар угаагдахгүй үлдэх магадлал өндөр хэсэг

Амархан бохирддог хэсэг нь хурууны үзүүр, хурууны салаа, гарын ар тал, эрхий хурууны бүдүүн үе, бугуй байдаг.

Гоожуурын ус болон шингэн савангаар гар угаах



(1) Бөгж болон бугуйн цагийг авна.

(2) Гарын хурууг гоожуурын усаар норгоно.

(3) Шингэн савангаас тохирох хэмжээгээр гарын алганд авна.

(4) Хоёр гарын алгыг хавсарч сайтар хөөсөртөл нь үрж угаана.

(5) Гарын ар талыг нөгөө гарын алгаар базлан угаана (хоёр гар).

(6) Хоёр гарын хуруугаа хавсарч гарын салаануудыг үрж угаана.

(7) Эрхий хурууг нөгөө гараар атгаж, эргүүлэн зүлгэж угаана (хоёр гар).

(8) Хурууны үзүүрүүдийг нөгөө гарын алганд үрж угаана (хоёр гар).

(9) Хоёр гарын бугуй хүртэл зөөлөн үрж угаана.

(10) Гоожуурын усаар сайтар зайлна.

(11) Цаасан алчуураар сайтар арчин бүрэн хатаана.

Спирттэй гар ариутгал



(1) Нүдэнд үзэгдэхүйц бохирдол байгаа үед юуны өмнө шингэн савангаар өмнөх хуудсанд заасан дараалаар гараа бүрэн угаана.

(2) Шүршигчтэй гарын ариутгалын шингэнийг алгаа хотойлгон гарандаа тохирох хэмжээгээр авна.

(3) Хоёр гарын алгыг хооронд хавсарч үрнэ.

(4) Хурууны үзүүр болон хурууны ар хэсгийг нөгөө гарын алганд үрнэ (Хоёр гар).

(5) Гарын ар талыг нөгөө гарын алгаар үрнэ (Хоёр гар).

(6) Хоёр гарын хуруугаа хавсарч гарын салаануудыг үрнэ.

(7) Эрхий хуруунуг нөгөө гараар атгаж, эргүүлэн үрнэ (хоёр гар).

(8) Хоёр гарын бугуй хүртэл зөөлөн үрнэ.

(9) Хаттал нь үрж зүлгэнэ.

5) Ослоос сэргийлэх болон аюулгүй байдлын арга хэмжээ

Асруулагч нь өндөр настай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй байх нь осол гарахад хялбар байдаг.

[Таварцаглах, унахаас сэргийлэх]

Асруулагч амьдрах орчинд явах, шилжин суух үйлдэл байнга хийгддэг. Тиймээс осол гарахад хялбар болдог.

● Асруулагчийн байр байдлыг сайтар ажиглана.

Байнга чаддаг байсан ч чадахгүй байх тохиолдол байдаг.

● Асруулагчийн хувцас, гутал нь тохиромжтой эсэхийг шалгана.

Углааш нь сугарахдаа амархан бөгөөд гулсахад хялбар байдаг. Өмдний түрий нь уртдах юм бол хөлд тээглэхэд хялбар болдог.

● Асрамжийн багаж хэрэгсэл ашиглах тохиолдолд урьдчилан шалгана.

Асрамжийн багаж хэрэгсэл нь эвдэрсэн байх нь ослын шалтгаан болдог.

Ойр орчмоо шалгана.

Шал нойтон байвал амархан халтирдаг.

Утсанд тээглэх юм бол таварцаглаж унахад хялбар болно.

⦿ Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага гэдэг нь үүсэн бий болж болзошгүй аюул заналыг урьдчилан тооцоолж, бүтэц зохион байгуулалттайгаар ослоос урьдчилан сэргийлэх ажиллагааг хийх явдал юм. Аюул заналыг урьдчилан тооцоолж, сэргийлэх боломжтой зүйлээс сэргийлэх гэх ойлголт нь чухалд тооцогддог.

Аюул заналыг мэдэхийн тулд тэмдэглэлийг зөв бичиж үлдээх явдал юм. Ослоос сэргийлэхийн тулд тэмдэглэл нь маш чухал байдаг.

Эрсдэлийн удирдлагын дэлгэрэнгүй жишээ

(1) Орноос тэргэнцэр рүү шилжих үед асруулагч нь унах шахсан.

(2) Яагаад ингэснийг бодож тунгаах
⇒ Тормоз түгжихээ мартсан байсан.
⇒ Тэмдэглэлд үлдээх.

(3) Урьдчилан сэргийлэх арга хэмжээ
⇒ Дараагийн удаагаас, тормоз түгжсэн эсэхийг заавал шалгана.
⇒ Мэдээллийг бүх хүмүүст хүргэнэ.

⦿ Гамшгаас сэргийлэх арга хэмжээ

Гамшиг гэдэг нь газар хөдлөлт, хар салхи, гал түймэр зэргээс үүдэх хохирлыг хэлнэ. Асрамжийн газар болон орон нутагт өдөр тутмын гамшгийн онцгой үеийн хамтран туулах тогтолцоог бүрдүүлсэн байдаг. Гамшиг нь хэзээ ч бий болсон сандарч тэвдэхгүй байх нь маш чухал.

● Шаардлагатай эд зүйлсийг базаана.

● Гамшгаас сэргийлэх сургуулилтыг хэрэгжүүлнэ.

БҮЛЭГ 2

Бие ба сэтгэлийн бүтэц

ХЭСЭГ 1 Бие болон сэтгэлийн бүтцийн ойлголт

ХЭСЭГ 2 Асаргаа шаардлагатай хүний тухай ойлголт

- Хөгшрөлтийн тухай үндсэн ойлголт
- Хөгжлийн бэрхшээлийн тухай үндсэн ойлголт
- Тэнэгрэлийн тухай үндсэн ойлголт

1 Бие болон сэтгэлийн бүтцийн ойлголт

1 Сэтгэлийн бүтцийн тухай ойлголт

1) Сэтгэлийн ойлголт

Хүнд өөрийн сэтгэл санаа болон бодол байдаг. Сэтгэл санаа болон бодол, илэрхийлэх арга нь хүн тус бүрт өөр өөр байдаг.

Тэрхүү ялгаатай байдал нь тухайн хүний зан ааш, өнөөг хүртэл туулж ирсэн амьдрал, боловсрол зэрэгтэй холбоотой байдаг. Сэтгэл санаа болон бодол нь наснаас хамааран өөрчлөгдөж, сэтгэл хөдлөл болон хүсэл сонирхол болон илэрхийлэгддэг.

Асрагч нь харилцагчийнхаа сэтгэлийг ойлгох шаардлагатай байдаг.

Сэтгэл хөдлөл

Сэтгэлийн үйл хөдлөл нь зүс царай болон хандлагаар илэрхийлэгддэг.

(Хүсэл сонирхол)

Хүсэл сонирхол нь урагш давшин ямар нэг зүйл хийе гэх сэтгэл санаа. Асрагч нь асруулагч хүсэл сонирхолтойгоор амьдралыг туулахад нь дэмжинэ.

●Хүсэл сонирхол

(Стресс)

Стресс гэдэг нь бие сэтгэлд үүсэх сандралын байдлыг хэлдэг. Стресс үүсгэгч хүчин зүйлсэд чимээ шуугиан болон халуун зэрэг биет хүчин зүйл, ядаргаа, нойргүйдэл, өлсөх зэрэг бие эрхтний нөлөөтэй хүчин зүйл, түгшүүр, уурлах, хөөрөл, харилцаа зэрэг сэтгэц, нийгмийн гаралтай хүчин зүйлс байдаг.

●Стрессийн хүчин зүйл

(Ой санамж)

Ой санамж гэдэг нь аливаа зүйлийг марталгүй санаж байх явдлыг хэлнэ.

Ой санамжийн процесс

Тогтоох
(Шинэ зүйлийг цээжлэх)

→

Хадгалах
(Мэдээллийг тууштайгаар хадгалах)

→

Эргэн санах
(Мэдээллийг гаргаж ирэх)

Ой санамжийн төрөл

Богино хугацааны ой санамж **Түр зуурын ой санамж**		
Урт хугацааны ой санамж **Урт хугацаагаар хадгалагдах ой санамж**	Тохиолдлын ой санамж	Тохиолдол болон дурсамжтай холбоотой ой санамж
	Семантик ой санамж	Мэдлэгтэй холбоотой ой санамж
	Цээжлэх ой санамж	Анхаарч бодолгүйгээр цээжлэх ой санамж
	Дараалын ой санамж	Биеэр цээжлэх ой санамж

(Хэрэгцээ)

Ямар нэг зүйлийг хүсэх байдлыг хэлнэ.

Сэтгэл судлаач Маслоу (Maslow, A. H.) нь хүний хэрэгцээ нь 5 шатлалаас тогтдог гэж зарласан. (Маслоуын хэрэгцээний шатлалын онол)

Маслоуын хэрэгцээний шатлалын онол

2 Биеийн бүтцийн ойлголт

1) Амьд байлгах, тогтвортой байдлын бүтэц (биеийн халуун, амьсгал, судасны цохилт, цусны даралт гэх мэт)

⦿ Гомеостаз (homeostasis: Тогтвортой байдал)

Гомеостаз гэдэг нь орчин нөхцөл өөрчлөгдсөн ч биеийн байдал нэгэн хэмд тогтвортой байхыг эрмэлзэх эрхтэн системийг хэлнэ.

Жишээлбэл: Халуун болж биеийн халуун нэмэгдэхэд хөлс ялгарч биеийн халууныг зайлуулан, хэвийн хэмд нь буцаах үйлдэл хийдэг.

● Гомеостазын ажиллагаа

(Амин шинж тэмдэг)

Амин шинж тэмдэг гэдэг нь, биеийн халуун, амьсгал, судасны цохилт, цусны даралт гэх мэт амьд байгаа шинж тэмдгийг илэрхийлэх зүйл юм. Эрүүл мэндийн байдал болон өөрчлөлт үзүүлэх үзүүлэлт болдог.

(1) Биеийн дулаан

- Биеийн дулаанд 1 өдрийн хэмнэл байдаг ба, өдрийн турш өндөр болж, унтах үеийн шөнө бага болдог.
- Хувь хүний онцлог их байдаг тул дундаж дулаан нь тухайн хүнээс хамааралд өөр байдаг.

Биеийн дулааныг хэмжих газар болон анхаарах зүйлс

Суга

Халуун хэмжигчийн үзүүрийг суганд тулгана.

Хэмжиж байх явцад гараараа сугаа сайтар хавчина.

Бусад арга

Дух болон чихэнд хэмждэг халуун хэмжигч байдаг.

Саажилттай байх тохиолдолд саажилт байхгүй талд нь хэмжинэ.

(2) Амьсгал

- Биед хүчилтөрөгч оруулж, нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулах явдал юм.
- Амьсгал нь тогтмол бөгөөд ухамсаргүйгээр хийгддэг.
- Амьсгалын тоо нь нас болон үйл ажиллагааны нөхцөл байдал, сэтгэл мэдрэлийн байдал, биеийн байдал, өвчтэй эсэх зэрэг хүчин зүйлээс хамааран өөрчлөгддөг.
- Амьсгалахад саадтай эсэх, цэртэй байгаа эсэх, хэржигнэж байгаа эсэхийг шалгана.
- Амьсгалахад хүндрэлтэй байгаа тохиолдолд уруул болон хумсны өнгө нь хөх ягаан туяатай болдог. Энэ байдлыг хөхрөлт гэдэг.

Амьсгалын хэмнэлийн долгион



Хэвийн

Насанд хүрсэн хүн 12 - 18 удаа/мин
Амьсгал авах болон
гаргах нь нэгэн жигд

(3) Судасны цохилт

- Судасны цохилт гэдэг нь зүрхний агшилтаар тараагуур судсанд дамжин ирсэн зүйл юм.
- Ихэнхдээ нас залуу байх тусам судасны цохилтын тоо олон, өндөр настай болоход тоо нь цөөн болдог.
- Судасны цохилтын тоо нь нас болон үйл ажиллагааны нөхцөл байдал, сэтгэл мэдрэлийн байдал, биеийн байдал болон өвчтэй эсэх зэрэг хүчин зүйлээс хамааран өөрчлөгддөг.
- Судасны цохилтын тоо, хэмнэл, хүчтэй сул байдлыг ажиглана.

Судасны цохилтыг хэмжих боломжтой гол хэсэг



Судасны цохилтыг толгой хэсэг, хүзүү, тохойноос гадна бугуйны дотор тал, хөлийн тавхай, тавхайн дээд хэсэг зэрэгт хүрснээр мэдэж болно.

(4) Цусны даралт

- Цусны даралт гэж зүрхнээс шахагдах цус судсыг (тараагуур судас) шахах хүчийг хэлнэ.
- 1 өдрийн дотор цусны даралт үргэлж өөрчлөгдөж байдаг.
- Цусны даралт нь төрх байдал болон үйл ажиллагааны нөхцөл байдал, сэтгэл мэдрэлийн байдал болон өвчтэй эсэх зэрэг хүчин зүйлээс хамааран өөрчлөгддөг.
- Даралт ихсэх үргэлжилбэл тархины судасны өвчин болон зүрхний өвчин зэрэг өвчлөл бий болох эрсдэл ихэсдэг.

Зүрхний нөхцөл байдал болон цусны даралтын хамаарал

Агших үе	Тэлэх үе
Цусны даралт: Өндөр	Цусны даралт: Бага
	
Агших үеийн цусны даралт (Дээд даралт) Зүрх агшиж байх үеийн (агших үе) даралт	**Тэлэх үеийн цусны даралт: (Доод даралт)** Зүрх суларч байх үеийн (тэлэх үе) даралт

Цусны даралт өндөр болох үе

Сэтгэл хөөрсөн үед

Нойр дутагдлын үед

Өтгөн хатах үед

Сандарсан үед

Температурын огцом өөрчлөлтийн үед

Огцом хөдөлгөөний үед

Шээс (өтгөн) барьж тэвчиж байх үед

Даралт ихсэхээр үүсэх өвчлөлүүд



2) Биеийн үндсэн бүтэц

- Биеийг толгой хэсэг болон хүзүүний хэсэг (хүзүү), их бие (цээжин бие), дээд мөч (хоёр гар) ба доод мөч (хоёр хөл) гэж хуваажболно.



[Мэдрэлийн систем]

Мэдрэлийн системийг төв мэдрэлийн систем ба захын мэдрэлийн систем гэж томоохон хоёр хуваараж болно.

⦿ Төв мэдрэлийн систем (тархи ба нугас)

- Тархи нь бүх биеэс мэдээлэл цуглуулж, задлан шинжилгээ, шалгалт хийж бүх биед команд түгээдэг.
- Нугас нь тархитай холбогдон бүх биеэс тархинд, тархинаас бүх биед мэдээлэл дамжуулах үүрэг гүйцэтгэхээс гадна, бие даан мэдээлэл шалгах болон команд ч гаргадаг.

⦿ Захын мэдрэлийн систем (тархины мэдрэл ба нугасны мэдрэл)

- Төв мэдрэлийн системтэй биеийн бүх эрхтэнд мэдээлэл дамжуулах үүрэг гүйцэтгэнэ.

● Мэдрэлийн судлын тархалт



Тархины байрлал болон гол ажиллагаа



⦿ Өөрийгөө удирдах мэдрэл

- Өөрийгөө удирдах мэдрэл нь дотор эрхтний ажиллагааг ухамсаргүйгээр хянаж байдаг мэдрэл бөгөөд, симпатик мэдрэл болон парасимпатик мэдрэл гэж хуваагдана.
- Симпатик мэдрэл гэдэг нь үйл ажиллагаатай байхад түгшүүртэй болох, уурлах, стрессдэх зэргийг мэдрэх зэрэг сандралтай үед ажиллах мэдрэл юм.
- Парасимпатик мэдрэл гэдэг нь унтах болон амрах зэрэг тайвширсан байдалтай байх үед ажиллах мэдрэл юм.

Өөрийгөө удирдах мэдрэлийн (симпатик мэдрэл ба парасимпатик мэдрэл) ажиллагаа

Симпатик мэдрэл (Идэвхтэй үйл ажиллагаатай)		Парасимпатик мэдрэл (Амралт)
Судасны цохилт хурдан болно.	Зүрх	Судасны цохилт удаашрах
Агших	Захын судас	Өргөсөх
Дээшлэх	Цусны даралт	Буурах
Томрох	Хүүхэн хараа	Багасах
Хөдөлгөөнийг хязгаарлах	Гэдэс	Хөдөлгөөн эрчимжих
Гуурсан хоолой сулрах	Амьсгалын зам	Гуурсан хоолой агших
Эрчимжих	Хөлрөх	Буурах

Өөрийгөө удирдах мэдрэл нь дотор эрхтний ажиллагаа зэргийг зохицуулж байдаг.
Өөрийгөө удирдах мэдрэл алдагдвал сэтгэл болон биед янз бүрийн өөрчлөлтүүд гарч ирнэ.

[Араг ясны тогтолцоо]

- Бүх биед их бага хэмжээтэй яс байдаг ба, тэдгээр нь бүгд нийлээд араг ясыг бүрдүүлдэг.
- Ясны гол үүрэг нь (1) Хүний биеийг тулж байх үүрэгтэй, (2) Хөдлөх эрхтэн болох үүрэг (3) Эрхтнийг хамгаалах, (4) Кальцийг хадгалах (5) Цус төлжүүлэх үйлчилгээтэй байдаг.
- Хүний нуруу нь физиологийн хувь S үсэг хэлбэрийн муруй байдаг.

Хүний биеийн араг ясны зураг



[Булчингийн тогтолцоо]

- Төрх байдлыг бүрдүүлж, хөдөлгөөн болон дотор эрхтний үүрэгт оролцдог.



[Мэдрэхүйн эрхтэн тогтолцоо]

- Юмыг харах (хараа), сонсох (сонсгол), үнэр мэдрэх (үнэртэх мэдрэмж), амт мэдрэх (амтлах мэдрэмж), хүрсэн зүйлийг мэдрэх (хүрэх мэдрэмж) гэдэг нь мэдрэхүйн эрхтэн нь тус бүр цочрол хүлээн авч, мэдрэхүйн мэдрэлээр дамжин тархинд мэдээлнэ.

Юмыг харах бүтэц

(2) Торлог бүрхэвч
Нүдний угийн нэг талыг томсгох нимгэн хальсан бүтэц. Дүрсийг тусгана.



(1) Нүдний болор
Тунгалаг бөгөөд зууван хэлбэртэй. Фокусын цэгийг тохируулна.

(3) Харааны мэдрэл
Торлог бүрхэвчид ирсэн цочрол тархинд хүрнэ.

Дуу авиа сонсогдох бүтэц



[Амьсгалын эрхтэн систем]

Амьсгал авахад орж ирсэн агаар нь амьсгалын замаар дамжина. Уушгинд хүчилтөрөгч дамжуулж, нүүрстөрөгчийн давхар ислийг амьсгалын замаар дамжин гадагшлуулдаг.

Амьсгалтай холбоотой эрхтэн



⦿ Ханиалга ба цэр

- Нян болон гэрийн шороо тоос зэрэг гадны биет амьсгалын замд орж ирэхэд ханиалга болон цэр байдлаар биеэс гадагшлуулахаар оролддог.

Удаан ханиалгах, цэрний өнгө өөрчлөгдөх зэрэг нь хэвийн бус байгаагийн тэмдэг.

[Цусны эргэлтийн эрхтэн тогтолцоо]

- Хүчилтөрөгч болон шим тэжээл, хаягдал зүйл зэргийг цус болон тунгалагийн урсгалаар дамжуулан, бүх биед зөөвөрлөж эргэлдүүлэх үүрэгтэй.

⦿ Зүрх

- Зүрх нь 4 тасалгаанд хуваагддаг.
- Тэлэх болон агшихыг ээлжилж хийн, шахуурга мэт цусыг шахан гаргадаг.

⦿ Судас болон цус

- Тараагуур судас гэдэг нь зүрхнээс бүх биед хүчилтөрөгч ихээр агуулах цусыг зөөн хүргэх судас юм.
- Хураагуур судас гэдэг нь нүүрстөрөгчийн давхар исэл болон хаягдал зүйлсийг ихээр агуулсан цусыг биеийн өнцөг булан бүрээс хураан татаж, зүрх болон уушгинд буцаан нийлүүлнэ.
- Хялгасан судас гэдэг нь тараагуур судаснаас хураагуур судсанд шилжих хэсгийг хэлнэ.

Бага эргэлт болон их эргэлт



Бага эргэлт дунд хүчилтөрөгчгүй цус нь хүчилтөрөгчөөр баялаг цус болон хувирдаг.

⦿ Их эргэлт болон бага эргэлт

Тараагуур судсанд тараагуур судасны цус, хураагуур судсанд хураагуур судасны цус урсаж, биеэр эргэлдэнэ. Үүнийг их эргэлт гэдэг.

Цус нь зүрхнээс уушги хүрэн зүрхэнд буцан ирэх эргэлтийг бага эргэлт гэдэг. Зүрхний баруун ховдлоос хураагуур судасны цус уушгины тараагуур судсаар дамжин уушгинд хүрэн, хийн солилцоо явагдаж тараагуур судасны цус болж, уушгины хураагуур судсаар дамжин зүрхний зүүн тосгуурт буцаж ирдэг.

[Хоол боловсруулах систем]

- Амны хөндийгөөс анус хүртэл хоол боловсруулах зам (улаан хоолой, ходоод, нарийн гэдэс, бүдүүн гэдэс) болон хоол боловсруулах ферментийг ялгаруулах эрхтэн байдаг.
- Хоол хүнс боловсруулалт, шимэгдүүлэлт явагдаж, хэрэгцээт шим тэжээлийг шингээн аван, боловсруулж, шимэгдүүлсний дараах үлдэгдлийг өтгөнөөр гадагшлуулах ажиллагаатай.

Хоол хүнсний боловсруулагдах дараалал болон эд эрхтний ажиллагаа



(1) Улаан хоолой
Залгиураар орж ирсэн хоол хүнс нь улаан хоолойгоос ходоод уруу явна.

(2) Ходоод
Ходоодонд хоол хүнс ирэхэд гүрвэлзэх хөдөлгөөн эхэлнэ. Ходоодны хүчлийн нөлөөгөөр хоол хүнсийг боловсруулна.

(3) Нарийн гэдэс
Хоол хүнсний шим тэжээлийг шингээнэ.

(4) Бүдүүн гэдэс
Шим тэжээл болон усны шингээлтийг илүү сайн хийж, өтгөн бүрэлдэнэ.

(5) Шулуун гэдэс
Өтгөн хуримтлагдахад шулуун гэдэсний хананд цочрол өгч, өтгөн гадагшлуулах хүсэл төрнө.

(6) Анус
Анусны хуниас булчин суларч, өтгөн гадагшилна.

[Шээс ялгаруулах тогтолцоо]

- Биеэс хаягдал зүйлсийг шээсээр гадагшлуулах үүрэгтэй.
- Шээс нь бөөрөнд бий болж, шээсний сувгаар дамжин давсагт түр зуур хуримтлагдсаны дараа шээсний сүвээр биеэс гадагшилна.



[Дотоод шүүрлийн тогтолцоо]

- Биеийн төрөл бүрийн ажиллагааг зохицуулах даавар ялгаруулах булчирхай бүхий эрхтэн юм.



[Дархлааны тогтолцоо]

- Дархлаа гэдэг нь гадаад орчинд байгаа төрөл бүрийн нян болон вирус зэрэг өвчин үүсгэгч нь биед нэвтрэн орсон үед эсэргүүцэл үзүүлж биеийг хамгаалах явдал юм.
- Амьдралын хэв маяг болон сэтгэл санааны байдал нь дархлааны хүчийг сулруулж, чангаруулдаг.

Дархлааны хүч чангарах амьдралын хэв маяг болон сэтгэл санааны байдал

Дархлааны хүчийг нэмэгдүүлэх явдал

- Тохиромжтой хөдөлгөөн
- Сайн инээмсэглэх
- Биеийг дулаан байлгах
- Шим тэжээлийн тэнцвэртэй хооллолт



Дархлааны хүчийг бууруулах явдал

- Наслалт
- Нойргүйдэл
- Ядаргаа
- Огцом их хөдөлгөөн
- Сэтгэл санааны стресс

3) Амралт, нойрсолттой холбоотой биеийн бүтэц

1. Амралт, нойрсолтын хэрэгцээ

- Амралт гэдэг нь үйл ажиллагаагаа завсарлаж бие сэтгэлээ тайвшруулан амраах явдлыг хэлнэ.
- Зохих хэмжээний амралт нь ядаргаа тайлах болон идэвхтэй амьдралын эх үндэс болдог.
- Нойрсолт нь тархийг тогтмол хугацаагаар амраадаг. Бие сэтгэлийн эрүүл мэндийг орхигдуулж болшгүй зүйл юм.

Сайн чанартай нойрсолтоос гарах үр дүн

2. Нойрсолтын бүтэц

- Хүний биед 1 өдрийн турш хийгдэх хэмнэлд хуваагдах тогтоох биеийн дотоод цаг байдаг.
- Биеийн дотоод цаг нь өглөөний гэрэл биед туссанаар ажиллаж эхлэх ба тогтоогдсон хэмнэлээр хуваагдан ажиллана.

3. Нойрсолтын цикл

- Нойр нь REM бус нойр (гүн нойр) болон, REM нойрыг (өнгөц нойр) нэг шөнийн дотор ээлжилж байдаг.
- REM бус нойрны үед тархи нь амарч байдаг. REM нойрны үед тархи нь сэрвэлзэхтэй ойролцоо төвшинд байдаг. Зүүдийг REM нойрны үед зүүдэлдэг гэгддэг.

REM бус нойр

REM нойр

4. Өндөр настны нойрсолтын онцлог

- Нойрсох хугацаа нь богино болдог.
- REM бус нойрны (гүн нойр) цаг багасдаг. Тиймээс шээс хүрэх болон аливаа юмны жаахан ч гэсэн дуунд хэдэн ч удаа сэрэх байдалтай болдог.

2 Асаргаа шаардлагатай хүний тухай ойлголт

1 Хөгшрөлтийн тухай үндсэн ойлголт

1) Хөгшрөлөөс үүдэх бие сэтгэлийн өөрчлөлтийн тухай ойлголт

1. Хөгшрөл гэдэг нь

Хүн нас нэмэх тусам бие сэтгэлийн үйл ажиллагаа буурдаг. Үүнийг хөгшрөл гэдэг. Хөгшрөл нь бүх хүнд үүсдэг.



(Хөгшрөлийн онцлог)

- Хувь хүний онцлог байдаг.
- Өвчин тусахдаа амархан болно.
- Амьдралын хэв маягийн нөлөөнд автана.

2. Хөгшрөлөөс үүдэх сэтгэл санааны өөрчлөлт

Сэтгэл санааны өөрчлөлт нь өндөр настны туулж өнгөрүүлсэн түүх, цаг үеийн нөхцөл байдал, амьдрах орчин зэргийн нөлөөнд автсаны улмаас хувь хүний онцлог ялгаатай байдаг. Тиймээс асаргаа хийх үед хүн нэг бүр өөр байхыг сайн ойлгох хэрэгтэй.

(Сэтгэл санааны өөрчлөлт)

- **Түгшүүртэй тайван бус, Бухимдалтай**

  Өнөөг хүртэл чадаж байсан зүйлээ чадахгүй байх зэрэг нь голлох шалтгаан болдог.

- **Гутарсан, Сул дорой**

  Нөхөр болон эхнэр, хамаатан садан, найз нөхдөөсөө хагацах болон өөрийн гүйцэтгэж ирсэн үүргийн өөрчлөлт зэрэг нь голлох шалтгаан болдог. Сэтгэл санааны өөрчлөлтөөс үүдэлтэйгээр сэтгэлийн хямралд орохдоо амархан байдаг.



3. Хөгшрөлөөс үүдэх биеийн өөрчлөлт

Хөгшрөлөөс үүдэлтэйгээр гадаад дүр төрх болон биеийн дотоод хэсэгт өөрчлөлт бий болдог.

Ганц биед олон төрлийн өвчтэй болж, архагшиж ужиграхдаа амархан болж, хүндрэл үүсэхэд хялбар болно.

2) Өндөр настанд түгээмэл тохиолдох өвчний шинж тэмдэг болон өвчний онцлог

Өндөр настнуудад түгээмэл тохиолдох өвчний шинж тэмдгүүд нь шингэн алдалт, халуурах, өтгөн хатах, хаван (хавагнах), нойргүйдэх, хатангирших, цооролт (орны холголт) зэрэг байдаг.

⦿ Өндөр настны өвчний онцлог

- Олон өвчинтэй болдог.
- Өвчний шинж тэмдэг зэрэг хувь хүний онцлог ихэсдэг.
- Өвчин тусахдаа амархан болж архагшихдаа хялбар болдог.
- Өвчний шинж тэмдэг гарахдаа хялбар болно. (Өвчний шинж тэмдэг нь нийтлэг бус)

3) Өндөр настанд түгээмэл тохиолдох өвчний шинж тэмдэг

Шингэн алдах

... Бие дэх усны хэмжээ нь хэвийн хэмжээнээс буурсан байдал

Биеийн дотор хэсэгт байх ёстой усны хэмжээ байсан ч шингэн уух хэмжээ болон гадагшлуулах хэмжээний тэнцвэр алдагдсанаас үүснэ.

Шалтгаан: Гүйлгэх, бөөлжих, халуурах, хөлрөх, шингэн авах хэмжээ буурах зэрэг.

Шинж тэмдэг: Уруул, амны хөндийн дотор тал, арьс хуурайшиж, шээсний давтамж болон шээсний хэмжээ нь цөөрч, цусны даралт багасан, судасны цохилох хурд нэмэгдэн, биеийн дулаан дээшлэх зэрэг.

Гол асаргаа

- Шингэн нөхнө.
- Тасалгааны температурын хяналтыг хийнэ.
- Усанд оруулсны өмнө болон дараа нь хөдөлгөөн хийлгэхэд шингэн уулгана.
- Хүндэрсэн шингэн алдалт нь үхэлд хүргэх аюултай. Эмнэлгийн байгууллагад үзүүлнэ.

⦿ Шингэний хэмжээний тэнцвэр

Хоол болон ундны усыг амаар нь уулгаж, гадагшлах шингэн болон орох шингэний тэнцвэрийг хадгалах нь эрүүл амьдралын хэв маягтай холбогдоно.

Халуурах

... Биеийн дулаан нь ердийн үеийнхээс өндөр байх байдал

Биеийн дулааны зохицуулалт нь их тархи болон харааны товгорын доод хэсэгт хийгддэг.

Шалтгаан: Халдварт өвчин, үрэвсэл, шингэн алдалт зэрэг.

Шинж тэмдэг: Халуун өндөр байх, нүүр улаан, нурмайх, хоолны дуршил муу байх зэрэг.

Гол асаргаа

- Шингэн нөхнө.
- Биеийн дулааныг хэмжинэ.
- Өндөр настны халуурах үеийн шинж тэмдгийг мэдэхэд хэцүү байх үе байдаг.
- Бусад шинж тэмдэг байгаа эсэхийг ч үзэж шалгана.

Өтгөн хаталт

... Бүдүүн гэдэс дотор урт хугацаагаар өтгөн хуримтлагдсан байдал

Хэвийн үед, идсэн зүйл нь 24 - 72 цаг орчим хугацаанд өтгөн болж гадагшилна.

Шалтгаан: Гэдэсний үйл ажиллагаа буурах болон булчингийн хүч буурах, хүндрэх хүслээ дарах зэрэг.

Шинж тэмдэг: Хоолны дуршил алдагдах, гэдэс өвдөх, дотор муухайрах зэрэг.

Гол асаргаа

- Хүнсний эслэг авах болон тохирох хөдөлгөөн хийлгэнэ.
- Хоолны дараа суултуурт суулгах дадал хэвшүүлнэ.
- Гэдэсний боловсруулах чиглэлийн дагуу иллэг хийх.

Гэдэсний боловсруулах чиглэлийн дагуу хийх иллэг



Хаван (Хавагнах)

... Эрхтний үйл ажиллагаа буурах болон булчингийн хүч буурах зэргээс үүдэн цусны эргэлт муудах, хэрэгцээгүй биеийн шингэн нь биед хуримтлагдах байдал.

Шалтгаан: Доод мөчний булчингийн хүч буурах, зүрх болон бөөрний үйл ажиллагаа буурах, өндөр настны шим тэжээл буурах, урт хугацаагаар суугаа байрлалд байх зэрэг.

Шинж тэмдэг: Жин нэмэгдэх зэрэг.

Гол асаргаа

- Хавангийн байрлал болон хэмжээг ажиглана.
- Саажилттай хүний өвчтэй талд хавагнахдаа амархан байдаг.
- Тохирох хөдөлгөөнийг хийх болон доод мөчийг дээш өргөх.
- Шалтгаан нь өвчин байх тохиолдолд эмчилгээ хийлгэнэ.



Загатнаа (Загатналт)

... Арьсанд загатнаа үүссэн байдал.

Шалтгаан: Хөгшрөлөөс үүдэн арьс хуурайших болон температур, чийгшлийн өөрчлөлт, хувцасны төрөл зэргээс үүсэх зэрэг

Шинж тэмдэг: Улайх, туурах, бухимдалтай болох зэрэг.

Гол асаргаа

- Арьсыг чийгшүүлнэ.
- Арьсанд шархлаа үүсгэхгүй байх болон нойргүйдэл үүсгэхгүй байхад анхаарна. Халдварлах тохиолдол ч байх учир эмчтэй хамтарна.

Нойргүйдэл

... Унтсан болохгүй, үүрэглэхдээ муу, гэнэт сэрэх зэрэг нойрсолт хангалтгүй байх байдал

Шалтгаан: Нойрсолтын байдал өөрчлөгдөх зэрэг

Шинж тэмдэг: Бухимдалтай болох, ядрах, сульдах зэрэг.

Гол асаргаа

- Амьдралын хэмнэлийг залруулах.
- Өглөө босоод наранд гарах.
- Тохиромжтой хөдөлгөөн хийх.
- Өдөр урт хугацаанд унтахаас зайлсхийх.
- Өрөөний доторх орчинг цэгцлэх
- Амьдрахад хүндрэлтэй зүйл байгаа бол эмчтэй хамтрах.

Даралт ихсэх

... Цусны даралт өндөр байх байдал.

Шалтгаан: Зүрх болон бөөрний өвчин, насжихтай холбоотой судасны өөрчлөлт, хоол болон хөдөлгөөн зэрэг амьдралын хэв маяг зэрэг

Шинж тэмдэг: Толгой өвдөх, амьсгаадах зэрэг.

Гол асаргаа

- Амьдралын хэв маягийг сайжруулна. Хэт идэхгүй, давсны хэрэглээг бууруулах зэрэг хоолонд анхаарна. Тохиромжтой хөдөлгөөн хийх.
- Эмчилгээнд хоолоор анагаах арга, хөдөлгөөнөөр анагаах арга, эмээр анагаах арга байдаг.
- Даралт ихсэх байдал үргэлжилбэл тараагуур судасны хатуурал үүснэ. Тараагуур судасны хатуурал нь тархины судасны өвчин болон зүрхний өвчин үүсгэх шалтгаан болно.

4) Өндөр настанд түгээмэл тохиолдох өвчин

Өндөр настанд түгээмэл тохиолдох өвчинд тархины судасны өвчин, зүрхний өвчин, уушгины үрэвсэл, буруу залгихаас үүдэлтэй уушгины үрэвсэл, чихрийн шижин, ясны сийрэгжилт, тэнэгрэл гэх мэт байдаг.

Асаргаа хийх үед эмчийн заавар хэрэгтэй байх хүн байдаг.

Тархины судасны өвчин

... Тархины судсанд үүсэх өвчин юм. Судас хагарах, бөглөрөх зэргээс үүдэлтэй байдаг. Гэмтэл авсан тархины хэсгээс үүдэн төрөл бүрийн эмгэг үлдэх тохиолдол байдаг.

Шалтгаан: Томоохон 2 төрөлд хуваагдана.

1 Тархины доторх судас бөглөрч үүсэх (тархины үхжил).

2 Тархины доторх судас хагарч үүсэх (тархины цус харвалт зэрэг).

Шинж тэмдэг: Толгой өвдөх, толгой эргэх, дотор муухайрах, бөөлжих, ухаан балартах, амьсгал доголдох, мэдрэхүйн өөрчлөлт зэрэг.

Гол асаргаа

- Асруулагчийн өвчний шинж тэмдэгт тохирсон асаргааг хийнэ.
- Амьдралын хэв маягтай хамааралтай тул хооллох хэмжээ болон орц, хөдөлгөөн зэрэгт анхаарна.

Тархины үхжил

(Судас бөглөрнө)



Тархины цус харвалт

(Судас хагарах зэрэг)



Зүрхний өвчин

... Зүрхний өвчлөл юм. Зүрхний судас бөглөрөх зэргээс үүдэлтэй байдаг.

Шалтгаан: Даралт ихсэх, чихрийн шижин, титэм судасны өөрчлөлт зэрэг.

- Зүрхний судас нарийссанаар үүснэ (зүрхний бах).
- Зүрхний судас бөглөрснөөр үүснэ (зүрхний шигдээс).
- Зүрхний үйл ажиллагаа буурснаас үүснэ (зүрхний дутагдал).

Шинж тэмдэг: Зүрхний бах байх тохиолдолд түр хугацаагаар хүчилтөрөгч дутагдаж цээжээр өвдөх зэрэг.

Зүрхний шигдээс байх тохиолдолд зүрхний булчин нь үхжих тул цээжээр хүчтэй өвдөлт үүсэх зэрэг.

Зүрхний дутагдал байх тохиолдолд амьсгалахад хүнд болох, амьсгаадах, амьсгал тасалдах, сульдах, хавагнах, жин нэмэгдэх, шээсний хэмжээ буурах зэрэг.

Гол асаргаа

- Хавагнах болон жин нэмэгдэх бол давс болон шингэний хэмжээг багасгах шаардлагатай.
- Амьсгал хүндрэлтэй байгаа үед хөдөлгөөнгүй тайван байдалд оруулж зүрхэнд ирэх ачааллыг бууруулах байрлалтай болгоно.

Зүрхэнд ирэх ачааллыг бууруулах байрлалд оруулах

Уушгины үрэвсэл

... Өвчин үүсгэгч нь уушгинд орсноор үүснэ.

Шалтгаан: Нян болон вирус зэрэг өвчин үүсгэгчийн халдвар зэрэг.

Шинж тэмдэг: Халуурах, сульдах, хоолны дуршил буурах зэргээр бүх биед өвчний шинж тэмдэг илэрнэ.
Ханиалга болон цэр зэргийн амьсгалын эрхтний өвчний шинж тэмдэг

Гол асаргаа

- Шингэн нөхөх болон идэхэд хялбар хоол өгөх зэрэг санаачилга гаргана.
- Өндөр настан байх тохиолдолд өвчний шинж тэмдэг илрэхгүй байх тохиолдол байдаг тул анхааралтай байх шаардлагатай.

Буруу залгихаас үүдэлтэй уушгины үрэвсэл

... Нян нь хоол хүнс болон шүлстэй хамт буруу залгигдан мөгөөрсөн хоолой болон гуурсан хоолойд орох замаар үүснэ.

Шалтгаан: Хоол хүнс болон ус нь улаан хоолой бус мөгөөрсөн хоолойд орсноор үүснэ.

Шинж тэмдэг: Халуурах, ханиалга болон цэр гарах, хоолны дуршил буурах зэрэг.

Гол асаргаа

- Хооллох үеийн байрлалд анхаарна. Хооллосны дараа хэвтүүлэлгүй суугаа байрлалд байлгана.
- Амны хөндийн арчилгааг хийнэ.
- Өвчний шинж тэмдэг байгаа тохиолдолд эмчтэй хамтрах.



Чихрийн шижин

... Цусан дахь сахарын хэмжээ өндөр болох бодисын солилцооны эмгэг өвчин юм.

Шалтгаан: Чихрийн шижин хоёр хэлбэртэй байдаг.

- 1-р хэлбэрийн чихрийн шижин нь инсулины ялгарал алдагдсан. Залуу хүмүүст ихэвчлэн илэрнэ.
- 2-р хэлбэрийн чихрийн шижин нь инсулины ялгарал буурсан. Өндөр настанд ихэвчлэн илэрнэ. Хэт их хооллолт, хөдөлгөөний дутагдал, стресс зэргээс үүдэлтэй амьдралын хэв маягийн өвчин гэж үздэг.

Шинж тэмдэг: Ам цангах, их ууж их шээх, жин буурах, сульдах зэрэг.

Гол асаргаа

- Эмчилгээнд хоолоор анагаах арга, хөдөлгөөнөөр анагаах арга, эмээр анагаах арга байдаг.
- Хоолоор анагаах аргад хоолноос авах илчлэгийг хязгаарлах.
- Хоолноос таашаал авах мэдрэмжийг бууруулахгүй байхаар анхаарна.
- Цусан дахь сахарын хэмжээ өндөр байснаар гэмтэж бэртэхэд эдгэхдээ удаан болно.
- Хүндрэлд торлог бүрхэвчийн өвчин, бөөрний эмгэг, мэдрэлийн эмгэг байдаг. Эмчтэй хамтран хүндрэлээс сэргийлэх шаардлагатай.

Чихрийн шижингийн хүндрэл



Мэдрэлийн эмгэг



Бөөрний эмгэг



Торлог бүрхэвчийн эмгэг

Ясны сийрэгжилт

... Ясны жин буурах зэргээр яс нь хэврэг болох өвчин юм.

Шалтгаан: Удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлэх, кальцийн дутагдал зэрэг.
Эмэгтэйчүүдэд эмэгтэй даавар буурснаар амархан үүсдэг.

Шинж тэмдэг: Нуруу бөгтийх, биеийн өндөр намсах, ууцаар өвдөх зэрэг.
Яс хэврэг болсон тул бүдэрч унахад яс хугарахад амархан болно.

Гол асаргаа

- Кальцийг агуулсан хоол хүнс өгөх.
- Хөдөлгөөн болон наранд шарах зэргийг хийнэ.
- Бүдэрч унахаас сэргийлэн амьдрах орчинг сайжруулна.

Өндөр настанд ихэвчлэн тохиох ясны хугарлын байрлал



2 Хөгжлийн бэрхшээлийн тухай үндсэн ойлголт

1) Хөгжлийн бэрхшээл гэдэг нь

Хөгжлийн бэрхшээл гэдгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид “Төрөл бүрийн саад хүндрэлтэй харилцан үйлчлэлийн замаар үүсэн бий болох зүйл” гэж тодорхойлсон байдаг. ICF (International Classification of Functioning, Disability and Health: Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал)-д хөгжлийн бэрхшээлийг сөрөг утгаар харах бус хүнийн хувийн шинж чанарын нэг гэж ойлгохоор тогтсон байдаг.



ICF: Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал



2) Хөгжлийн бэрхшээлийн төрөл, учир шалтгаан болон онцлог

[Тулгуур эрхтний бэрхшээл]

Тулгуур эрхтний бэрхшээл гэдэг нь өвчин болон осол гэмтлээр хөдлөх тулах эрхтэн болон их биед гэмтэл аван, өдөр тутмын амьдрал болон нийгмийн амьдралд оролцоход хүндрэлтэй болох байдлыг хэлнэ.

Өвчин болон осол гэмтлээс үүдэх гар хөлийн гэмтэл, тархи болон нугасны мэдрэлийн гэмтэл, өвчин болон түүний дараах ужиг үлдэц зэргээс үүдэх үе мөч болон нугасны өөрчлөлт, өрөөл татанхай байдлаас үүсэх зүйлс байдаг.

Амьдрахад хүндрэлтэй байдал нь хөгжлийн бэрхшээлийн байрлал болон хэм хэмжээнээс хамааран хувь хүн тус бүр өөр өөр байдаг. Хөдөлгөөний эрхтэнд үүссэн бэрхшээлээс үүдэн оюуны бэрхшээл зэрэг нь хавсран үүсэх тохиолдол байдаг. Таяг болон тэргэнцэр, хиймэл хөл зэрэг асруулагчид тохирсон асрамжийн багаж хэрэгслийг ашиглана.



Тайлбар

ICF (Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал)

ICF гэдэг нь хүний амьдралын үйл ажиллагааг ангилж, тэдгээрт хамаарал бүхий этгээдүүдийг бүхэлд нь төсөөлөн харж ойлгохын төлөө хийгдсэн зүйл юм. Хүний амьдралын үйл ажиллагаа гэдэг нь бие сэтгэлийн үйл ажиллагаа, бие эрхтний бүтэц, үйл ажиллагаа, оролцоо гэсэн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж амьдрахад шаардагдах ур чадвар болон ажиллагаа, орчин зэргийн зүйлийг хэлнэ

[Харааны бэрхшээл]

Харааны бэрхшээл гэдэг нь хараа болон харах талбар зэрэг эд зүйлийг харах ажиллагаанд бэрхшээл байх бөгөөд, өдөр тутмын амьдрал болон нийгмийн амьдралд хүндрэлтэй болох байдлыг хэлнэ.

Шалтгаан нь олдмол бус байх тохиолдолд (төрөлхийн) болон өвчин, осол гэмтэл, хөгшрөл зэргээс байж болно. Чихрийн шижингийн шалтгаанаар харааны бэрхшээлтэй болох жишээ өсөн нэмэгдэж байна.

Огт хардаггүй хүн, гэрэл мэдрэх хүн, бага хүрээгээр хардаг хүн зэрэг харааны бэрхшээлийн илрэх хэлбэр нь янз бүр байдаг.

Харааны бэрхшээлийн харагдах хэлбэр



Төвийн бараан толбо ба харах талбарын алдагдал

Харах талбарын хумигдал

Нэг талын орон зайг орхиж харах

[Сонсголын бэрхшээл]

Сонсголын бэрхшээл гэдэг нь чихнээс сонсголын төв мэдрэлд дамжуулах зам нь гэмтэл авч, сонсогдохгүй байх эсвэл сонсоход хүндрэлтэй болох байдлыг хэлнэ. Сонсголын хэм болон бэрхшээлийн байрлал, шинж тэмдэг илэрсэн үед нийцүүлэн ангилна.

Муу сонсох гэдэг нь дуу чимээ сонсогдоход хүндрэлтэй байхыг хэлнэ. Харилцааны арга хэрэгслээр сонсголын аппарат ашиглах, бичгээр ярилцах, дохионы хэл, уншиж ярилцах (амны хайрцаг унших) зэрэг байдаг.

Бичгээр ярилцах

Дохионы хэл

Уншиж ярилцах (амны хайрцаг унших)



Сонсголын аппарат

[Хэл ярианы бэрхшээл]

- Хэл ярианы бэрхшээл гэдэг нь их тархины хэл ярианы төв мэдрэл болон авиа гаргахад оролцдог эрхтэн нь гэмтсэнээс болж хэл яриа ашигласан харилцаанд бэрхшээл тулгарсан байдлыг хэлнэ.
- Их тархины хэл ярианы төв мэдрэл нь олдмолоор гэмтэл авч, “сонсох”, “ярих”, “унших”, “бичих” зэрэг үйлдэл нь хүндрэлтэй болох байдлыг хэлнэ.
- Харилцааны арга хэрэгсэл нь бичгээр ярилцах болон зурагт карт ашиглах зэргээр бэрхшээлээс хамааран өөр өөр байдаг.

Хэлгүй болох эмгэгтэй асруулагчийн төлөв байдал

Ярихыг хүсэж байгаа боловч үг үргэлжлэн гарахгүй байх байдал

[Зүрхний үйл ажиллагаа буурах]

Бүх биед цусыг шахахад хүндрэлтэй болох байдал.

Судасны цохилт асуудалтай болсон асруулагчид дунд зүрхний аппаратыг цээжиндээ суулгуулсан хүн ч байдаг.

Гол асаргаа

- Цээжинд суулгасан хэсэгт цохилт өгөх хөдөлгөөн зэргээс зайлсхийнэ.

Хиймэл зүрхний аппарат



[Бөөрний үйл ажиллагаа буурах]

Цусыг цэвэрлэхэд хүндрэлтэй болох байдал.

Бөөрний үйл ажиллагаа буурсан асруулагчид хиймэл диализ хийх замаар цусыг цэвэрлэдэг.

Хиймэл диализийн бүтэц



Гол асаргаа

- Диализэд орсон өдөр усанд оруулахаас зайлсхийнэ.
- Шилжүүлэг хийсэн талын гараар хүнд юм өргүүлэхгүй байх.
- Давс болон усны хэрэглээг хязгаарлана.

[Амьсгалын эрхтний үйл ажиллагаа буурах]

Амьсгалахад хүндрэлтэй болох байдал.

Хангалттай сайн амьсгалж чадахгүй болсон асруулагчид хүчилтөрөгчийн эмчилгээний аргыг ашиглана.

Зөөврийн хүчилтөрөгчийн аппарат

Хүчилтөрөгч өтгөрүүлэгч



Гол асаргаа

- Хүчилтөрөгч өтгөрүүлэгч ашиглах үед гал гаргахаас зайлсхийнэ.
- Халдварт өвчнөөс сэргийлэх нь чухал.
- Цахилгаан тасарсан үед зориулан нөөц батарей зэргийг базаах.

[Давсаг, шулуун гэдэсний үйл ажиллагаа буурах]

Давсаг болон шулуун гэдэсний өвчнөөр шээс болон өтгөн нь гарч чадахгүй болох байдал.

Хэвлийд мэс засал хийн ялгадас гаргахын тулд ам (стом) гаргана.

Хиймэл давсаг болон хиймэл анус байдаг. Байрлал н өвчнөөс хамааран ялгаатай байна.

Хиймэл давсаг



Хиймэл анус



Гол асаргаа

- Асаргаа нь стомыг далдлах сав (уут) дотор ялгадсыг боловсруулна.
- Стом орчмоор улайлт үүсвэл эмчид мэдэгдэнэ.

[Оюуны бэрхшээл]

Оюуны бэрхшээл гэдэг нь оюун санааны торнил хөгжил нь бүхэлдээ хоцорсон хүнийг хэлнэ. Өдөр тутмын амьдралд саад бий болсон бол ямар нэгэн тусгай халамж асаргаа хэрэгтэй болно.

Гол асаргаа

- Амьдралын үе шатанд нь таарсан ажиллагаа хийнэ.
- Асруулагчийн байдлыг мэдэж, асруулагчид тохирсон асаргаа хийнэ.

[Сэтгэцийн бэрхшээл]

Сэтгэцийн бэрхшээл гэдэг нь сэтгэцийн өвчлөлийн улмаас сэтгэцийн үйл ажиллагаанд бэрхшээл үүсэн, өдөр тутмын амьдрал болон нийгэм дэх оролцоод хүндрэл үүссэн байгаа байдлыг хэлнэ. Өвчний байдал нь хүндрэхэд дүгнэх чадвар болон үйлдлээ хянах хяналт нь огцом буурах тохиолдол байдаг. Сэтгэцийн өвчлөлд шизофрени болон сэтгэлийн эмгэг зэрэг байдаг.

Сэтгэцийн бэрхшээлтэй хүний өвчний шинж тэмдэг нь сонсголын хий үзэгдэл болон дэмийрэл, сэтгэлийн хямрал зэрэг байдаг.

Сэтгэцийн бэрхшээлийн өвчний шинж тэмдэг

Дэмийрэл

Сонсголын хий үзэгдэл болон дэмийрэл үүсэх.

Сэтгэлийн хямрал

Сэтгэл санаа нь хямарч, үг цөөрөн, сэтгэлээр унасан байдал

Хөөрөл

Энгийн үетэй харьцуулахад сэтгэл санаа нь огцом хөөрлийн байдалтай болж сул задгай болсон байдал.

3 Тэнэгрэлийн тухай үндсэн ойлголт

1) Тэнэгрэлийн тухай ойлголт

Тархи нь хүний үйл ажиллагааг хянаж байдаг хэсэг юм. Тэнэгрэл нь тархины мэдрэх үйл ажиллагаа нь ямар нэгэн шалтгаанаар бууран өдөр тутмын амьдрал болон нийгмийн амьдралд саад үүсэх өвчнийг хэлнэ.

Тархины ажиллагаа

Тэнэгрэлийг ойлгохын тулд тархины ажиллагааг мэдэх шаардлагатай. Тархины ажиллагаа буурвал амьдралд саад бэрхшээл бий болгоно.

Их тархины 4 талбар болон үйл ажиллагаа



Тэнэгрэлийн тодорхойлолт

Мэдрэх үйл ажиллагаа гэдэг нь

Ой санамж
(Тогтоох, санах)



Хэл яриа
(Ярих, ойлгох)

Үйл хөдлөл
(Өдөр тутмын амьдрал дээрх үйл хөдлөл)

Таних
(Юмыг таних)

Төлөвлөгөө, дараалал тогтоох зэрэг

Марталт болон тэнэгрэлийн ялгаа

Тэнэгрэлийн голлох өвчний шинж тэмдэгт марталт нь байдаг. Марталт нь нас нэмэгдэхээс хамааран илрэх өвчний шинж тэмдэг боловч, тэнэгрэлийн марталт гэдэг нь өөр байдаг.

Марталтын ялгаа

Нас нэмэгдэхээс үүдэлтэй марталт	Тэнэгрэлийн марталт
Туршлагаас нэг хэсгийг нь мартах	Туршлагыг бүхлээр нь мартах
Ахиц байхгүй	Ахицтай
Марталтыг өөрөө мэдэж байх	Мартсанаа өөрөө мэдэхгүй
Амьдралд саад бэрхшээл байхгүй	Амьдралд саад бэрхшээлтэй.

2) Тэнэгрэлийн асаргааны гол санаа

Тэнэгрэлтэй хүнд асаргаа хийхдээ,

(1) Асруулагчийн байр суурьиас бодох
Тухайн хүн төвтэй асаргаа хийх шаардлагатай.

(2) Асруулагчийн амьдралыг ойлгох
Тогтвортой амьдралын дэмжлэг шаардлагатай.

(3) Асруулагчийн чадах зүйлийг харж дэмжлэг үзүүлнэ.
Тухайн хүний ур чадвар хүсэл сонирхлыг өдөөн гаргаж дэмжлэг үзүүлнэ.

3) Тэнэгрэлийн гол шалтгаан болох эмгэг болон шинж тэмдгүүд

Тэнэгрэлийн шалтгаан болох эмгэгт, (1) Альцгеймер хэлбэрийн тэнэгрэл, (2) Судасны гаралтай тэнэгрэл, (3) Лею биенцэрт тэнэгрэл, (4) Дух шанааны дэлбэнгийн хэлбэрийн тэнэгрэл байдаг.

Тэнэгрэлийн гол шалтгаан болох эмгэг болон шинж тэмдгүүд

Ангилал	Тархины байдал	Голлох шинж тэмдгүүд
(1) Альцгеймер хэлбэрийн тэнэгрэл	Тархи нь хатангиршина. Хөгшрөлтийн толбо бий болно.	• Шинж тэмдэг илрэх, Ахиц нь удаан. • Ой санамжийн эмгэгээс эхэлнэ. • Сэтгэл санааны байдал нь сайн байх нь олон. • Ахицыг удаашруулах эм байдаг.
(2) Судасны гаралтай тэнэгрэл	Тархины судасны өвчнөөр судас нь бөглөрөн зарим хэсэгт тархины эс үхнэ.	• Үе шаттайгаар ахина. • Тал саажилт болон хэл ярианы бэрхшээл зэрэг. • Чаддаг зүйл болон чадахгүй зүйл байна.
(3) Лею биенцэрт тэнэгрэл	Дагзны дэлбэн нь хатангиршиж лею биенцэр бий болно.	• Харагдахгүй зүйлийг харна (Харааны хий үзэгдэл). • Бага багаар алхах зэрэг (Паркинсоны шинж тэмдэг) • Зүүдэндээ ярих зэрэг (Нойрсолтын эмгэг).
(4) Дух шанааны дэлбэнгийн хэлбэрийн тэнэгрэл	Тархины духны дэлбэн ба шанааны дэлбэн нь хатангиршина.	• Шалтгаан болон хоригийг хүлээн авахгүй. • Зан ааш өөрчлөгдөх. • Тогтсон загварын үйлдэл. • Сэтгэл хөөрөл ба түрэмгийлэлтэй.

4) Тэнэгрэлийн өвчний шинж тэмдэг

Тэнэгрэлийн өвчний шинж тэмдэг нь дараах төрлүүдэд ангилагдана.

Гол шинж тэмдэг: Тархины эмгэг үүснэ.

Ой санамжийн эмгэг, чиг баримжаа алдах, гүйцэтгэх үйл ажиллагааны эмгэг, ойлгох ба дүгнэх чадварын алдагдал зэрэг.

Үйл хөдлөл ба сэтгэцийн эмгэг (BPSD): Орчин, асруулагчийн зан ааш болон шинж чанар, хүнтэй харилцах харилцаа зэрэгт үүснэ.

Тайван бус ба бухимдах, хий юм үзэх, дэмийрэх, сэтгэл хөөрөлд автах ба түрэмгий үйлдэл хийх, дэмий тэнэх зэрэг.

Тэнэгрэлийн гол шинж тэмдэг болон үйл хөдлөл ба сэтгэцийн шинж тэмдэг



[Гол шинж тэмдэг]

(1) Ой санамжийн эмгэг

Ой санамжийн эмгэг нь шинэ баримт болон мэдээллийг тогтоож чадахгүй болох эмгэг юм. Тэнэгрэлийн гол цөм болох шинж тэмдэг.

(2) Чиг баримжаа алдах

Чиг баримжаа алдах нь цаг хугацаа, газар, хүнийг мэдэрч чадахгүй болох эмгэг юм.

- Шөнө дунд босон гадагш гарахаар оролдох зэрэг үйлдэл хийнэ.
- Гэр бүлийн хүнээ гадны хүн мэтээр бодох зэрэг.

(3) Гүйцэтгэх үйл ажиллагааны эмгэг

Гүйцэтгэх үйл ажиллагааны эмгэг нь дараалыг ойлгохоо больж, үйлдэл хийх боломжгүй болно.

- Хоол хийх дараалыг мэдэхээ болино.

(4) Ойлгох ба дүгнэх чадварын алдагдал

- Ойлгох ба дүгнэх чадварын буурснаар эд зүйлийг дүгнэх чадваргүй болно.
- Мөнгөний тооцоо хүндрэлтэй болно.

[Үйл хөдлөл ба сэтгэцийн шинж тэмдэг (BPSD)]

⦿ Үйл хөдлөлийг шинж тэмдэг

(1) Сэтгэл хөөрөл ба түрэмгий үйлдэл

Сэтгэл хөөрөл ба түрэмгий үйлдэл нь юу хийж байгаагаа ойлгохгүй тайван бус сэтгэлээс үүдэлтэй үйлдэл юм. Өвдөлт, бие засах хүсэл, шээх хүсэл зэргийг сайн дамжуулж чадахгүй байх нь ч түрэмгий үйлдэлтэй холбоотой гэж үзэгддэг.

(2) Дэмий тэнэх

Дэмий тэнэх нь ямар нэг зорилго байгаа эсэх болон тэвчээртэйгээр байж чадахгүй учир шалтгааны улмаас эргэн тойрон алхах үйлдлийг хэлнэ.

⦿ Сэтгэцийн шинж тэмдэг

Тэнэгрэлтэй хүн нь тайван бус түгшүүртэй байдал болон хүн төвөгтэй байдалд байдаг.

(1) Хий юм үзэх

Хий юм үзэх нь бодитоор байхгүй зүйлийг байгаа мэтээр мэдрэх явдлыг хэлнэ.

(2) Дэмийрэх

Дэмийрэх нь бодит бус зүйлийг байгаа зүйл мэтээр мэдрэх явдлыг хэлнэ.

⦿ Тэнэгрэлтэй хүнд асаргаа хийхэд анхаарах зүйлс

- Татгалзалгүйгээр үг болон үйл хөдлөлийг хүлээн авна.
- Яриаг сайтар сонсож, тайтгаруулах мэдрэмжийг өгөхөөр оролдох.
- Ойлгох чадвараас нь хамааруулан ойлгомжтойгоор богино үгээр харилцана.
- Өглөө босоод унтах хүртэл амьдралын хэмнэлийг бүрдүүлнэ.
- Түгшүүртэй байдлыг арилгахын тулд хамт бодож үйл хөдлөл хийнэ.
- Өрөө болон ойр орчмыг нь хялбархан өөрчлөгдөхгүй байхаар болгоно.

БҮЛЭГ 3

Харилцааны ур чадвар

ХЭСЭГ 1 Харилцааны үндэс

ХЭСЭГ 2 Асруулагчтай харилцах харилцаа

ХЭСЭГ 3 Багийн харилцаа

1 Харилцааны үндэс

1 Харилцааны ач холбогдол

Харилцаа гэдэг нь харилцан бие биенийхээ санаа бодлыг солилцох, хуваалцах явдал юм.

Харилцагчтайгаа итгэлтэй харилцаа бий болгох аргаар харилцааны арга техникийг суралцах шаардлагатай байдаг.

Харилцааны дүр зураг

2 Мэдээлэл хүргэх арга

Мэдээлэл хүргэх аргад хэл яриа ашигласан хэл ярианы харилцаа болон биеийн хөдлөл болон нүүр царайны илэрхийлэл зэргээр хэл ярианы бус зүйл ашигласан хэл ярианы бус харилцаа гэж байдаг.

1) Хэл ярианы харилцаа

Хэл ярианы харилцаанд хэлний авиа болон дохионы хэл зэргээс үүдэх харилцан яриа, үсгээр мэдээлэх арга байдаг.

Хэл ярианы харилцааны жишээ

Хэлний авиа

Дохионы хэл

Үсэг

2) Хэл ярианы бус харилцаа

Хэл ярианаас бусад харилцааны аргад биеийн хөдөлгөөн, гарын хөдөлгөөн зэрэг дохио зангааны илэрхийлэл байдаг.



3 Харилцааны арга техник

Харилцааг бий болгохын тулд дараах зүйлсийг ухамсарлаж харилцана.

Сонсох

- Сонсох гэдэг нь үнэн сэтгэлээсээ яриаг сонсох хандлагатайгаар анхааралтай, үнэн бодитоор яриаг сонсох явдал юм.

Хуваалцах

- Хуваалцах гэдэг нь харилцагчийн санал болон санаа бодол зэргийг өөрөө дээрээ ижилтгэн хүлээн авч мэдрэх явдал юм.
- Харилцагчийн байр суурь дээрээс ойлгохыг эрмэлзэх нь чухал юм.

Хүлээн зөвшөөрөх

- Хүлээн зөвшөөрөх гэдэг нь харилцагчийн санаа бодол, саналыг татгалзалгүйгээр зөвшөөрөлгүйгээр хүлээн авах явдал юм.

2 Асруулагчтай харилцах харилцаа

1 Яриаг сонсох техник (Тууштайгаар сонсох техник)

Асрагч нь асруулагчид илүү сайн амьдралын дэмжлэг үзүүлэхийн тулд асруулагч болон түүний гэр бүл бусад мэргэжилтэнтэй харилцдаг.

1) Асруулагчийн үнэт зүйлийг хүндэтгэх

Асруулагч нь төрж өссөн үе болон амьдран сууж ирсэн орчин зэргээс хамааран өөр өөрийн үнэт зүйлтэй байдаг. Асрагч нь асруулагчийн сэтгэл хөдлөл, бодол санаа, үнэт зүйлийг хүндэтгэж асаргаа үзүүлнэ.

2) Хэл ярианы харилцаанд анхаарах зүйлс

[Үгийн хэрэглээ]

Асрагч нь эелдэг үгийн хэрэглээнд анхаарна.

[Асуух техник]

Асрагч нь мэдэхийг хүссэн зүйлээ асруулагчаас зөвхөн асуугаад байх бус, асруулагчтай харилцах хоёр талт харилцаанд анхаарна.

Асуултад, (1) хаагдмал асуулт болон (2) нээгдмэл асуулт гэж байдаг.

(1) Хаагдмал асуулт

Хаагдмал асуултад “Тийм” эсвэл “Үгүй”, “А” эсвэл “Б” гэх зэрэг, харилцагч нь ганц үгээр төвөггүй хариулах боломжтой асуулт юм. Хаагдмал асуулт л асуугаад байвал, нэг талыг барьсан харилцаа болж хувирна.

(2) Нээгдмэл асуулт

Нээгдмэл асуултад “Юу гэж бодож байна вэ?” “Яамаар байна вэ?” зэрэг харилцагч нь чөлөөтэй хариулж болохуйц асуулт байдаг. Гэхдээ, “Яагаад” гэх учир шалтгаан асуух нээгдмэл асуулт асуугаад байвал буруутгаад байна гэж бодогдох тохиолдол байдаг тул анхаарах хэрэгтэй.

Асуултын жишээ

[Давталт]

Асруулагчаас гарсан үгийг асрагч нь давтан хэлэх замаар “яриаг сонсож байгаа” гэх мэдээг дамжуулах боломжтой байдаг.

Давталтын жишээ

3) Хэл ярианы бус харилцаанд анхаарах зүйлс

[Дохио зангаа ба болон зүс царай]

Асрагч нь асруулагчийн дохио зангаа болон зүс царайг ажиглан, түүнд тохирсон харилцаагаар харилцана.

[Харааны түвшин]

Асрагч нь харааны түвшингээ тааруулж асруулагчтай харилцана. Асруулагчтай харааны түвшингээ тааруулахгүй бол яриаг нь сонсож байгаа эсэх нь дамжигдахад төвөгтэй болдог.

Харааны түвшин тааруулах арга



Харааны түвшин тааруулах

Асрагч нь асруулагчийг дээрээс харахад айдас дарамт төрүүлдэг.

[Ярианы хурд]

Тайван удаан ярианы хурдаар, дөлгөөнөөр, зохих хэмнэлийг авч ярина.

[Толгой дохих болон уулганч байдал]

Хүзүүний босоо чигт толгой дохих болон асруулагчийн ярианд “Тийм шүү” гэх уулганч байдлыг илэрхийлэх нь асруулагчийн ярьж буй ярианд сайн сонсож ойлгохыг хичээж байгаа харилцааг илэрхийлнэ.

[Төрх байдал ба биеийн хөдөлгөөн, гарын хөдөлгөөн]

Асрагч нь асруулагчийн өөдөөс эгцлэн харан харилцана.

- Хүний ярианд сонсох үед гар хөлөө хөлөө жийж суух нь харилцагчид сөрөг төсөөлөл өгнө.
- Биеийн хөдөлгөөн болон гарын хөдөлгөөн хийх утга нь улс болон соёлоос хамааран ихээхэн ялгаатай байдаг.

Төрх байдалд анхаарах зүйлс



Эгцлэн харж ярих.



Гар ачих.

Хөл ачих.



Хөлөө жийж суух.

[Зай болон биед хүрэх]

Улс орноос хамааран ойр зайнаас ярилцах болон биед хүрэх нь элгэмсэг сэтгэгдлийг төрүүлэх явдал байдаг.

Япон улсад эелдэг дотно байсан ч тодорхой хэмжээгээр зайнаас харьцах нь сэтгэлд таатай байдаг гэх хүн олон байдаг.

Харилцагчийн биед хүрэх нь цаг үе болон хүч, хэмнэл зэргээс үүдэн харилцагчид хүргэх мэдээллээс хамаарна.

Биед хүрэх жишээ

Гарыг нь атгаж харилцах.

2 Тайлбар болон зөвшөөрөл (мэдээлсэн зөвшөөрөл)

Асруулагч нь өөрийн тааваар амьдрахын тулд асрагч нь асруулагчийн шийдвэрийг дэмжинэ. Асрагч нь асруулагчийн шийдвэрийг дэмжихтэй холбоотой дараах зүйлсийг анхаарна.

(1) Сонголтыг санал болгоно.
(2) Тус бүрийн сонголтын давуу тал болон сул талын тухай ойлгомжтойгоор тайлбарлана.
(3) Асруулагчийн өөрийн бодлоор сонгуулж, шийдүүлнэ.

Асруулагчийн шийдсэн зүйлийг биелүүлэхийн тулд асрагч нь түүний сонголтыг хүндэтгэн дэмжинэ.

3 Асруулагчийн төлөв байдалд тохирсон харилцаа

Асруулагч нь өвчин болон эмгэгээс үүдэлтэйгээр харилцахад хүндрэлтэй болох тохиолдол байдаг. Асрагч нь асруулагчийн өвчин болон эмгэгт нийцүүлэн тохирох харилцааны аргыг сонгох нь чухал.

1) Төрөл бүрийн эмгэгийн онцлог шинжид тохирсон харилцааны аргын ач холбогдол

Өвчин болон эмгэгийн үүднээс харилцаанд бэрхшээл бий болох тохиолдол байдаг. Асрагч нь асруулагчийн харилцаанд ямар бэрхшээл байгаа эсэхийг таньж мэдэн, тухайн хүнд тохирсон харилцаагаар харилцана.

Сүүлийн жилүүдэд харилцааны арга хэрэгслээр ICT (мэдээлэл харилцаа холбооны технологи) ашиглах нь эрчимжиж байна.

2) Харааны бэрхшээлтэй хүнтэй харилцах

1. Харааны бэрхшээлтэй хүнтэй харилцах онцлог

Харааны бэрхшээл гэдэг нь, нүд нь харахгүй, мөн нүд нь юм харахад хүндрэлтэй болох эмгэг юм. Хараанаас нь мэдээллийг хангалттай сайн авч чадахгүй тул эд зүйл хүртэлх зай болон байрлалыг мэдэхгүй байх үе байдаг.

2. Харааны бэрхшээлтэй хүнтэй харилцах үед анхаарах зүйлс

⦿ Хараанаас бусад мэдээллийг ашиглана.

Эд зүйлийн байрлал болон онцлог зэргийг дэлгэрэнгүйгээр нарийвчлан тайлбарлана. Мөн дуу хоолойн өнгө болон ярих арга зэргийг ухамсарлах нь чухал.

Шууд хүргэж үзүүлэх аргаар ч мэдээлэл дамжуулж болно.

⦿ Нэрийг нь хэлж харилцах

Асрагч нь юу ч хэлэлгүйгээр асруулагчийн биед хүрвэл сандаргадаг тул заавал эхлээд хэлнэ. Хэлэх үед асруулагчийн нэрийг хэлсний дараа ярина.

Мөн, асрагч нь өөрийн нэрийг хэлж байх нь ч чухал юм.

● Нэрийг нь хэлж, дуудна.



⦿ Газар болон чигийг дэлгэрэнгүй тайлбарлана.

Газрын тайлбар хийх үед “Таны баруун талд” “Миний дуу гарч байгаа талд” зэрэг дэлгэрэнгүйгээр тайлбарлана. Хооллох үед хоолны байрлалыг дамжуулах тохиолдолд цагийн хуваарьт тааруулан байрлалыг тайлбарлах цагийн байрлал гэх арга байдаг.

3. Харааны бэрхшээлтэй хүнтэй харилцах арга болон дэмжих хэрэгслийн жишээ

Асруулагчийн харааны бэрхшээлийн байдалд тохируулан дэмжих хэрэгсэл ашиглах замаар харилцааг хялбаршуулж болно.

(Брайль үсэг)

Нүд нь харахгүй хүний мэдээлэл дамжуулах хэрэгсэл нь брайль үсэг болон хөтөч хавтан байдаг.

Брайль үсэг



Хөтөч хавтан

3) Сонсголын бэрхшээлтэй хүнтэй харилцах

1. Сонсголын бэрхшээлтэй хүнтэй харилцах онцлог

Дуу чимээ сайтар сонсогдохгүй тул ганцаардаж, гутарсан байх нь их бөгөөд сэтгэлийн дэмжлэг ч хэрэгтэй.

2. Сонсголын бэрхшээлтэй хүнтэй харилцах үеийн анхаарах зүйлс

- Харилцан зүс царай болон амны хөдөлгөөнөөр ойлгогдохоор өөдөөс нь харж ярина.
- Сонсож чадах тал байвал тэр чихэнд нь тэнд нь ярина.
- Удаан бөгөөд тодорхой дуу авиа гаргана.
- Хэт ихээр чанга дуу авиа гаргаж болохгүй.
- Болж өгвөл чимээ шуугиангүй газар харилцан ярилцана.

3. Сонсголын бэрхшээлтэй хүнтэй харилцах арга болон дэмжих хэрэгслийн жишээ

(Уншиж ярилцах (амны хайрцаг унших))

Амны хөдөлгөөнийг уншиж харилцаж болно.

Амны хөдөлгөөний уншиж ярилцах



(Бичгээр ярилцах)

Цаас, бичгээр ярилцах төхөөрөмж ашиглан харилцаж болно. ICT зэргийг ч ашиглаж байгаа.

Бичгээр ярилцах харилцан яриа

(Дохионы хэл)

Гарын хурууны хөдөлгөөн болон нүүр хүзүү зэргийн үйлдлийг эвлүүлэн утга гарган дамжуулна.

Дохионы хэл ашигласан харилцан яриа



(Сонсголын аппарат)

Сонсголын аппарат нь микрофоноор дуу чимээг хурааж чангаруулан чихэнд хүргэх төхөөрөмж юм.

Сонсголын аппарат ашигласан харилцан яриа



4) Хэлгүй болох эмгэгтэй хүнтэй харилцах

1. Хэлгүй болох эмгэгтэй хүнтэй харилцах онцлог

Хэлгүй болох эмгэг нь их тархины хэл яриатай холбоотой хэсэгт гэмтэл авах замаар “Яриа сонсоод ойлгох” “Бичсэн юмыг хараад ойлгох” “Ярих” “Үсэг бичих” зэрэг чадвар буурч алдагдахыг хэлнэ.

2. Хэлгүй болох эмгэгтэй хүнтэй харилцах үеийн анхаарах зүйлс

- Богино ойлгомжтой үгээр тайван тодорхой ярих.
- Зураг болон фото зураг, биеийн хөдөлгөөн, гарын хөдөлгөөн зэрэг хэл ярианаас бусад харилцааг ашиглана.
- Дэлгэрэнгүй андуурч хэлэхэд нь зэмлэхгүй байх.

Хаагдмал асуулт асууж, “Тийм” “Үгүй” зэрэг хариулахад хялбар байдлыг ашиглана.

3. Хэлгүй болох эмгэгтэй хүнтэй харилцах арга болон дэмжих хэрэгслийн жишээ

- Ярианаас гадна биеийн хөдөлгөө, гарын хөдөлгөөн зэргийг ашиглана.
- Зураг, дүрс зэргийг ашиглана.



5) Тэнэгрэлтэй хүнтэй харилцах

1. Тэнэгрэлтэй хүнтэй харилцах онцлог

Мэдрэхүйн үйл ажиллагаа алдагдах замаар ижил төрлийн харилцан яриаг хэдэн ч удаа давтах болон асрагч, асруулагч хооронд харилцаа үүсэхгүй байх тохиолдол үүснэ.

2. Тэнэгрэлтэй хүнтэй харилцах үеийн анхаарах зүйлс

- Удаан ярина
- Ойлгомжтой үгээр, богино өгүүлбэрээр илэрхийлнэ.
- Тухайн хүний яриа нь бодит байдлаас өөр байсан ч түүнийг тоолгүйгээр тэр чигээр нь хүлээн зөвшөөрч авч хуваалцана.

Тэнэгрэлтэй хүнтэй харилцах жишээ

Тэнэгрэлтэй хүний тайван бус байдлыг хүлээн зөвшөөрнө.

3 Багийн харилцаа

1 Тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл хуваалцах үндсэн ойлголт

1) Мэдээлэл хуваалцах зорилго

Асаргааг зөвхөн асрагч бус, эмч болон бусад төрлийн ажилтнуудтай хамтран багаар гүйцэтгэдэг. Асруулагчид илүү сайн асаргааны үйлчилгээ үзүүлэхийн тулд асаргааны агуулаг болон эмчилгээтэй холбоотой мэдээллийг багаар хуваалцдаг.

⦿ Мэдээлэл хуваалцах арга

Тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл хуваалцах

Асаргааны төлөвлөгөө, тохиолдлын тэмдэглэл, хүлээлцэх тэмдэглэл зэрэг байдаг.

Хурал (яриа) хийх замаар мэдээллийг хуваалцах

Асруулагчийн тухай мэдээллийг ажилчдад хүргэх хүлээлцэх ажил болон асаргааны холбогдолтой агуулгыг шалгах хурал зэрэг байдаг.

Тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл хуваалцах



Хүлээлцэх байдал

2) Асаргаа дахь тэмдэглэлийн ач холбогдол

Өндөр чанартай асаргаа үзүүлэхийн тулд асрагч нь асруулагчийн мэдээлэлтэй танилцах шаардлага байдаг. Асрагч нь асруулагчийн төлөв байдал болон асруулагчид хийсэн ажиллагаа болон түүний хариу үйлдлийг тэмдэглэнэ.

Тэмдэглэлийн ач холбогдолд илүү сайн асаргааны үйлчилгээ үзүүлэх болон багаар асрах ажиллагааг хийх 2 гол ач холбогдол байдаг.

3) Асаргааны тэмдэглэлийг бичих үндэс

(1) Ой санамж бүрэн гүйцэд байхад бичнэ.

(2) Огноо болон цагийг үнэн зөвөөр нь тэмдэглэнэ.

Бичсэн зүйл нь хэзээ болсон зүйл болохыг хожим ойлгох боломжтой байхаар огноог тэмдэглэнэ.

(3) Бодит байдлыг тэмдэглэнэ.

Бодит байдалд “Субъектив баримт” болон “Объектив баримт” байдаг.

Бодит байдал	Агуулга
Субъектив баримт	• Асруулагч нь харсан зүйлээ болон тухайн хүний туршлага, тухайн хүний гомдол зэрэг • Асруулагчийн үг яриа зэрэг
Объектив баримт	• Асрагчийн харж ажигласан зүйл • Цусны даралт болон биеийн дулааны хэмжээ, шинжилгээний өгөгдөл зэрэг.

Тэмдэглэлийн жишээ

Объектив баримт

Субъектив баримт

Огноо	Агуулга
2019/7/20	Өглөөний 8 цагийн бие засуулах асаргаа, ○○ гуайн ахар сүүлд 1см орчим улайлт ажиглагдсан. Өөрөөс нь асуухад, “Өвдөлт байхгүй” гэж байсан. Сувилагчид мэдэгдэж, цооролтын эхний шат болохыг тогтоосон.

(4) Нэг удаа уншаад ойлгох агуулгыг тэмдэглэх.

Тэмдэглэлийг дараах 6 зүйл тодорхой байхаар бичнэ.

(1) When	⇒	Хэзээ
(2) Where	⇒	Хаана
(3) Who	⇒	Хэн
(4) What	⇒	Юуг
(5) Why	⇒	Яагаад
(6) How	⇒	Хэрхэн

Ойлгомжтой бичвэрийн жишээ

(1) Хэзээ (2) Хаана (3) Хэн

○ сарын ○ өдөр Токио өртөө дотор А гуай

түрийвчээ гээгдүүлсэн тул цагдаагийн пост хамт

явсан.

(4) Юуг (5) Яагаад (6) Хэрхэн

4) Хувийн мэдээллийг (хувь хүний мэдээлэл) хамгаалах болон нууцыг хадгалах

Асрагч нь мэдээлэлтэй ажиллах тухай хангалттай сайтар анхаарахгүй бол болохгүй. Ялангуяа хувийн мэдээллийн (хувь хүний мэдээлэл) хамгаалалт болон нууцыг хадгалах нь мэргэжилтэй ажилтны ажил мэргэжлийн ёс зүйн хувьд хатуу чанга шаардагддаг.

Хувийн мэдээллийг (хувь хүний мэдээлэл) хуваалцах тохиолдолд хувийн мэдээлэл ашиглах зэргийн тухай асруулагч хувь хүнээс зөвшөөрөл авах шаардлагатай.

(Хувийн мэдээллийн (хувь хүний мэдээлэл) төрөл)

Овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар, хувь хүний царай орсон зураг зэрэг

Хувийн мэдээллийг (хувь хүний мэдээлэл) хамгаалахын тулд дараах зүйлсэд анхаарна.

- Ажлын байрнаас гадуур асруулагч болон ажлын ириаг ярихгүй.
- Интернет болон SNS зэргээр асруулагч болон ажил олгогчийн тухай мэдээлэл бичихгүй.



2 Мэдээлэх ба Холбогдох ба Зөвлөлдөх

1) Мэдээлэх ба холбогдох

Асрагч нь багаар асаргааг үзүүлдэг. Тиймээс өөрийн асруулагчтай холбоотой анхаарсан зүйл болон өөрийн ажлын явц байдал зэргийг багийн дотор мэдээлж холбогдож, хуваалцана.

Мэдээлэх ба холбогдох цаг үе нь агуулгаас хамаараад өөр өөр байна. Осол гарсан тохиолдол зэрэг яаралтай байх тохиолдолд нэн даруй мэдээлнэ.

Мэдээлэл илгээх жишээ

- Товчхон дамжуулна.
- Бодит байдал болон дүгнэлтийг ялгаж салган дамжуулна.
- Газар болон цаг хугацааг бодолцож мэдээлнэ.

Мэдээлэл хүлээн авах тал

- Тэмдэглэж авна.
- Бодит байдал болон дүгнэлтийг ялгаж салган сонсоно.
- Давтан асуух

2) Зөвлөлдөх

Зөвлөлдөх нь тулгамдсан зүйл болон ойлгохгүй зүйл байгаа тохиолдолд бусад ажилчид болно мэргэжилтэн зэргээс зөвлөгөө авах явдал юм. Шаналгаатай үед өөрөө ганцаараа шийдвэр гаргалгүй зөвлөгөө хүснэ.

БҮЛЭГ 4

Амьдралыг тэтгэх арга техник

хэсэг 1 Хөдөлгөөний асаргаа

хэсэг 2 Хооллох асаргаа

хэсэг 3 Бие засах асаргаа

хэсэг 4 Бие арчлах асаргаа

хэсэг 5 Усанд орох, ариун цэвэр сахих асаргаа

хэсэг 6 Гэрийн ажлын асаргаа

1 Хөдөлгөөний асаргаа

1 Хөдөлгөөний ач холбогдол

1) Асаргаа дахь хөдөлгөөний ач холбогдол

Хүн хөдөлгөөн хийх замаар үйл хөдлөлийн цар хүрээг өргөжүүлдэг. Үйл хөдлөлийн цар хүрээ өргөнтэй амьдрал нь бие эрхтэн болон сэтгэл мэдрэлийн үйл ажиллагааг сайжруулахад нөлөөлдөг. Өдөрт тутмын амьдралын талбарт хоолны газар хоол идэх, ариун цэврийн өрөөнд бие засах, халуун усанд усанд орох гэх мэтээр тухайн үйлдлийг хийх газар хүртэл шилжин хөдөлж байдаг. Хөдөлгөөн нь бүгдээрээ амьдралын үйлдэлтэй холбогдож байдаг.

ADL, IADL-н хамаарал

Тайлбар

ADL (Өдөр тутмын үйл ажиллагаа) ба IADL (Хөдөлмөрийн хэрэгсэл, багажтай харилцах өдөр тутмын үйл ажиллагаа)

ADL нь нэг хүн бие даан амьдрахын тулд хэрэгжүүлэх нэгэн цогц биеийн үйл ажиллагааны үндсэн нэгдлийг хэлнэ. ADL-д хөдөлгөөн, хооллолт, хувцаслалт, бие засах, усанд орох зэрэг багтана. IADL нь гэр орон болон бүс нутагт амьдрахын тулд шаардагдах ур чадвар юм. IADL-д мөнгөний удирдлага, худалдан авалт, угаалга, унаа тэрэг ашиглах, харилцаа холбооны төхөөрөмж ашиглах зэрэг багтана.

2 Хөдөлгөөнтэй холбоотой бие болон сэтгэлийн бүтэц

1) Хөдөлгөөнд оролцох биеийн хэсэг

Хөдөлгөөнд төрөл бүрийн булчин болон үе оролцож байдаг.

Хөдөлгөөнд оролцох биеийн гол хэсэг



2) Биеийн байрлал

Биеийн байрлал нь босож байгаа байрлал (босоо байрлал), сууж байгаа байрлал (суугаа байрлал), хэвтэж байгаа байрлал (хэвтэх байрлал) гэж хуваагдана.

(1) Босоо байрлал

Босоо байрлал



(2) Суугаа байрлал

Орон дээр хөлөө унжуулж суух



Сандал дээр суух (суугаа байрлал)



Хөлөө жийж суух



Хагас хэвтээ (Өндийлгөсөн байрлал)

(3) Хэвтэх байрлал

Дээш харж хэвтэх байрлал



Хажуугаар хэвтэх байрлал



Доош харж хэвтэх байрлал



3) Биеийн таатай байрлал

Дээш харж хэвтэх таатай байрлал

Илүү тогтвортой болсон байдал.



Хажуугаар хэвтэх (баруун) таатай байрлал

Цээжний хэсгийн өмнө дэр тавина. Хоёр доод мөчний хооронд, баруун хөлийн доор дэр ивнэ.



Хагас хэвтээ (Өндийлгөсөн байрлал) таатай байрлал

Хоёр доод мөчийг доороос өргөнө. Доороос өргөх боломжгүй тохиолдолд хоёр өвдөгний доор дэр ивнэ.



Тайлбар

Нуруу амраах

Биеийн дээд хэсгийг өндийлгөж, асруулагчийн нурууг орноос нэг удаа холдуулна. Үүнийг нуруу амраах гэж хэлдэг. Нуруу амраахыг хийснээр цооролтоос сэргийлнэ.

4) Хатангирших

Хатангирших нь урт хугацаанд хөдөлгөөнгүй болон үйл ажиллагаа буурсны тохиолдолд бий болох бие сэтгэлийн төрөл бүрийн нөхцөл байдлыг хэлнэ.



5) Цоорол

Цоорол нь хэвтэх хугацаа урт байснаас үүдэн, яс нь арьсаа цоолон гарч ирсэн хэсэгт цусны эргэлтийн эмгэг үүсгэн, арьс үхжих явдал юм. Орны даавууны үрчлээ болон биеийн байрлал өөрчлөх үрэлт ч цооролтын шалтгаан болдог.

⦿ Цооролтоос сэргийлэх арга

(1) Боломжтой бол орноос хөндийрүүлэх.

(2) Тогтмол хугацаанд биеийн байрлалыг солих

(3) Шим тэжээл сайтар авахуулах.

● Цоорол хялбархан үүсдэг хэсэг



6) Хөдөлгөөнд холбогдох асрамжийн багаж хэрэгсэл

Тэргэнцрээс бусад хөдөлгөөнд холбогдох асрамжийн багаж хэрэгсэлд таяг, алхуулагч, өргөгч зэрэг байдаг.



Т хэлбэрийн таяг Салаа хөлт таяг



Т хэлбэрийн таяг: Хөнгөн бөгөөд эвтэй байдлаараа шалгарсан.
Салаа хөлт таяг: Т хэлбэрийн таягаас дэмжлэгийн талбай өргөн бөгөөд, өвчтэй талд биеийн жинг тулах хүч нь хангалтгүй тохиолдолд ашиглана.

Алхуулагч: Таягтай харьцуулахад дэмжлэгийн талбай нь өргөн тул тогтвортой байна.

Өргөгч нь асрагчийн асаргааны ачааллыг хөнгөвчлөх үр дүнтэй юм.

(1) Таазны гүйдэг өргөгч	(2) Дугуйтай өргөгч
	

3 Шилжин суух ба хөдөлгөөний асаргааны үед

1) Биеийн асаргааны үндэс

Бүх асаргааны ажилбарт ижил байдаг.

(1) Асруулагчийн биеийн байдлыг шалгах.

Асаргаа хийх үед заавал урьдчилан асруулагчийн биеийн байдлыг шалгана. Биеийн байдал сайнгүй байвал хүчлэн үргэлжлүүлэлгүйгээр эмчид мэдэгдэнэ.

(2) Асруулагчид одоо хийх гэж байгаа зүйлийн зорилго болон агуулгыг тайлбарлан зөвшөөрөл авна.

Асаргаа хийх үед асруулагчийн өөрийн шийдвэрийг хүндэтгэн үзэхгүй бол болохгүй. Мөн урьдчилан асаргааны тухай мэдэх нь асруулагчийг тайван болгож, сэтгэлд хүрсэн дэмжлэгийг авах боломжтой болдог.

(3) Орыг асаргаа хийхэд хялбар байхаар өндөрт тохируулна.



Орны өндрийг тохируулж, асрагчийн нуруунд үзүүлэх ачааллыг бууруулна.

Тайлбар

Бие даах дэмжлэг

Чадахгүй зүйлд нь дэмжинэ. Тиймээс асруулагчийн байдлыг сайн шалгах шаардлагатай.

Номонд асрагчийн ажиллагааг тайлбарласан боловч, үнэндээ бол асруулагчийн чадах зүйлийг асруулагч өөрөөр нь хийлгэнэ.

2) Оронд нь хөрвөөлгөх асаргаа

Энд зүүн тал саажилттай асруулагчаар жишээ аван тайлбарлав.

(1) Биеийн байдлыг шалгана.

(2) Асруулагчид хийх гэж байгаа зүйлийн талаар тайлбарлаж зөвшөөрөл авна.

(3) Орыг асаргаа хийхэд хялбар болгож өндрийг тохируулна.

(4) Асруулагчийн өвдгийг нугална.

(5) Өвчтэй талыг дээш харуулж, хажуугаар хэвтэх байрлалд оруулна.

Биеийг эвхрүүлэн жижигсгэвэл дэмжлэгийн суурь талбай багасна.

(6) Асруулагчийн ууцыг хойш нь татна.



Хажуугаар хэвтэх байрлал нь тогтвортой байлгана.

(7) Асруулагчийн хөлийг таатай байрлалд нь шилжүүлнэ.

Дэмжлэгийн суурь талбай томорвол бие тогтвортой болно.

3) Дээш босгох асаргаа (Баруун хажуугаар хэвтэх байрлалаас орон дээр хөлөө унжуулж суух байрлал)

(1) Асруулагчийн биеийн байдлыг шалгана.

(2) Асруулагчид хийх гэж байгаа зүйлийн зорилго болон тайлбарыг хийж зөвшөөрөл авна.

(3) Орны өндрийг асруулагч нь орон дээр хөлөө унжуулж суусан үед хоёр хөлийн ул нь шаланд хүрэхүйц өндрөөр тохируулна.

(4) Өвчтэй талыг дээш харуулж, хажуугаар хэвтэх байрлалд оруулна.

(5) Асруулагчийн хоёр хөлийг орны ирмэг хүртэл зөөнө.

(6) Асруулагчийн хоёр хөлийг орноос унжуулан баруун тохойг чангалуулна. Дараа нь цээжин биеийг нь дээшлүүлнэ.



(7) Сэтгэл санаа болон биеийн байдлыг шалгана.

(8) Хоёр хөлийн ул нь шаланд хүрч байгаа эсэхийг шалгана.



Суугаа байрлал нь тогтвортой болно.

4) Босгох асаргаа (Орон дээр хөлөө унжуулж суух байрлалаас босоо байрлалд)

(1) Асруулагчийн биеийн байдлыг шалгана.

(2) Асруулагчид хийх гэж байгаа зүйлийн зорилго болон тайлбарыг хийж зөвшөөрөл авна.

(3) Ирмэгдэж суулган суудлыг засна.

(4) Асруулагчийн эрүүл талын хөлийг арагш нь шилжүүлнэ. Энэ үед асрагч нь өвчтэй талд байрлана.

Эрүүл талын хөл нь хангалттай ачаалал авч босгохын тулд ингэж байна.

(5) Өвчтэй талын өвдөг нугалрахаас сэргийлэн асрагч нь гараараа тулна. Цээжин биеийг сайн бөхийлгөнгөө босгоно.



Асруулагч нь өвчтэй тал уруу унахаас сэргийлэхийн тулд ингэж байна.

(6) Сэтгэл санаа болон биеийн байдлыг шалгана.

Тайлбар

Өвдөг нугалрах

Өвдөг нугалрах гэдэг нь босоо байрлал болон алхаж байх үед өвдөг чангаралгүй, “намсхийн” нугалран махийхыг хэлнэ. Унах шалтгаан болно.

5) Тал саажилттай асруулагчийг алхуулах асаргаа

(Таягтай алхах)

Таягтай алхахад 2 үйлдэлт алхаа болон 3 үйлдэлт алхаа гэж байдаг.

●2 үйлдэлт алхаа болон 3 үйлдэлт алхааны харьцуулалт

Алхаа	2 үйлдэлт алхаа	3 үйлдэлт алхаа
Хөлөө гишгэх дараалал	(1) Таяг болон өвчтэй тал → (2) Эрүүл тал 	(1) Таяг → (2) Өвчтэй тал → (3) Эрүүл тал 
Тогтвортой байдал	Нам	Өндөр

Өвчтэй талын хөлөөс эхэлж алхах шалтгаан нь алхаж эхлэхэд тулах чадвар өндөртэй эрүүл талд биеийн жинг хуваарилах шаардлагатай байдаг учраас юм.

Таягтай алхуулах асаргаа

Асрагч нь асруулагчийн өвчтэй талын ард байрлана. Шаардлагаас хамааран цээжин бие болон уцыг тулна.



(Шатаар өгсөх)

Асрагч нь аюулгүй байдлыг хангах үүднээс асруулагчийн 1 гишгүүрийн доор (ард) байрлана. Асруулагч нь (1) таяг → (2) эрүүл талын хөл → (3) өвчтэй талын хөл гэх дараалаар гишгэн тулж шатаар өгсөнө.



Шатны бариул байгаа бол шатны бариулаас барьсан тал нь тогтвортой байна.

(Шатаар буух)

Асрагч нь аюулгүй байдлыг хангах үүднээс асруулагчийн 1 гишгүүрийн доор (урд) байрлана. Асруулагч нь (1) таяг → (2) өвчтэй талын хөл → (3) эрүүл талын хөл гэх дараалаар гишгэн тулж шатаар бууна.



Шатны бариул байгаа бол шатны бариулаас барьсан тал нь тогтвортой байна.

6) Харааны бэрхшээлтэй асруулагчийг алхуулах асаргаа

Алхах хурдыг асруулагчийн түвшин тааруулна. Догол болон эргэх булан зэрэг, нөхцөл байдал өөрчлөгдөх үед урьдчилан амаар тайлбар хийнэ.

Чиглүүлэх үеийн үндсэн байдал

7) Тэргэнцрийн асаргаа

Тэргэнцрийн бүтэц болон эд ангийн нэршил



(Тэргэнцрийн талаар анхаарах зүйлс)

- Тэргэнцэр ашиглах үед дугуйн хий болон тоормосны ажиллагаа зэргийг урьдчилан шалгана. Дугуйн хий бага болон тормоз нь хангалттай ажиллахгүй байх нь аюултай.
- Зогсоож байхдаа заавал тоормос залгана. Хүн суугаагүй байх үедээ ч хөдлөх нь аюултай тул зогсоож байхдаа тоормос залгана.

8) Орноос тэргэнцэрт шилжин суух

(1) Асруулагчийн биеийн байдлыг шалгана.

(2) Асруулагчид хийх гэж байгаа зүйлийн зорилго болон тайлбарыг хийж зөвшөөрөл авна.

(3) Орны өндрийг асруулагч нь орон дээр хөлөө унжуулж суух байрлалд байгаа үед хоёр хөлийн ул нь шаланд хүрэхүйц өндрөөр тохируулна.

(4) Тэргэнцрийг асруулагчийн эрүүл талд нь байрлуулан, тоормос залгана.

(5) Асруулагчид эрүүл талын гараар хол талын тохойн тавиураас бариулна. Асрагч нь өвчтэй талын өвдөг нугалрахаас сэргийлнэ.

Өвчтэй талын өвдгийг тулна.

Саажилттай хүнийг шилжүүлэхдээ эрүүл талаас нь эхэлж хөдөлгөх нь үндсэн зарчим болно.

(6) Асруулагчид толгойгоо бөхийлгөнгөө аажуухан босон, тэргэнцэр рүү биеийг эргүүлнэ.

(7) Асруулагчийг лав суулгана. Гишгүүрт хөлийг нь тавина.

(8) Сэтгэл санаа болон биеийн байдлыг шалгана.

9) Тэргэнцэртэй хөдөлгөөний асаргаа

(1) Асруулагчийн биеийн байдлыг шалгана.

(2) Асруулагчид хийх гэж байгаа зүйлийн зорилго болон тайлбарыг хийж зөвшөөрөл авна.

(3) Асруулагчийн хөлийг гишгүүрт тавина.

(4) Асруулагчийн гар зүтгэх дугуйнд хавчуулагдахаас сайтар сэргийлнэ.

(5) Тоормосыг салган хөдлөх тухай мэдэгдэж, тэргэнцрийг хөдөлгөнө.



(Догол дээгүүр гарах)

Доголын өмнө ирээд түр зогсон, асруулагчид догол байгаа тухай тайлбарлана.



Эргэлддэг дугуйг доголын дээгүүр аажуухан гаргаж, дараа нь зүтгэх дугуйг өргөнө.

(Доголоор буух)

Доголын өмнө ирээд түр зогсон, асруулагчид догол байгаа тухай тайлбарлана. Арагш харан зүтгэх дугуйг алгуур буулгана.





Зүтгэх дугуйг сайтар татан эргэлддэг дугуйг зөөлөн буулгана.

(Өгсүүр зам уруудах)

Огцом өгсүүр буух тохиолдолд асруулагчийг арагш харуулах тухай тайлбарлана.

Тэргэнцрийг арагш харуулан уруудна.

Арагш харан уруудах нь асруулагч тэргэнцрээс гулсан унахаас сэргийлж буй хэрэг юм.

2 Хооллох асаргаа

1 Хооллохын ач холбогдол

Хооллолт нь амаараа идэх явдлыг хэлэх бөгөөд биед хэрэгцээт шим тэжээлийг авч, үйл ажиллагаа болон амьдралыг залгуулах зүйл юм.

Амаараа идэх, амтлах нь их тархинд цочрол өгч, амьдралын хэмнэлийг бий болгоход тусална.

Идэх нь амьдралаас авах таашаал бөгөөд, хүн хоорондын харилцааг үүсгэх боломж болж байдаг.

2 Хооллолттой холбоотой бие болон сэтгэлийн бүтэц

Хүн нь өлссөн байгааг тархиндаа мэдэрч, идэх хүсэл төрдөг.

- Хоолны ширээ хүртэл явж, төрх байдлаа бэлдэнэ. Дараа нь хоол хүнсийг нүдээрээ нягтална. Савх болон халбага зэргийг ашиглан хоолыг амандаа хийнэ. Зажлаад залгина.
- Хооллолт нь хараа болон үнэртэх мэдрэмжээр идэх зүйлийг нягталж, амтлах мэдрэмж болон хүрэх мэдрэмжээр амь болон зажлуур мэдэрдэг.
- Хооллолттой олон үйл ажиллагаа холбогддог.

⦿ Идэх болон зажлах дараалал

Өмнөх үе		• Хоолны өнгө хэлбэр, үнэр зэргийг мэдрэх. • Шүлс ялгарна.
Бэлтгэл үе		• Аманд орсон хоолыг зажлан буталж, шүлстэй холилдож хоолны бөөн (болус) бий болно.
Аманд байх үе		• Болусыг амны хөндийгөөс төвөнх рүү илгээнэ. • Илгээхэд ихэвчлэн хэл оролцдог.
Залгиур үе		• Залгих рефлекс үүсэн, болус нь залгиураар дамждаг. • Төвөнхийн халхавч нь хааж, болус нь мөгөөрсөн хоолойд орохоос сэргийлнэ.
Улаан хоолойд байх үе		• Болус нь улаан хоолойноос ходоод уруу явна.

Энэ дараалал дотор аль нэг газар н эмгэг байх юм бол аюулгүйгээр хоол идэхэд хүндрэлтэй болдог. Үүнийг идэх ба залгих эмгэг гэдэг.

3 Хооллох асаргааны үед

⦿ Хооллох асаргаанд анхаарах зүйлс

- Хоолны дуртай дургүйг шалгана.
- Өвчний эмчилгээ болон харшил зэргийн улмаас идэж болохгүй зүйл байгаа эсэхийг анхаарна.
- Асруулагчийн зажлах болон залгах чадварт тохируулан зөөлөн болгох, жижиглэн идэхэд хялбар болгоно.
- Халуун юмыг халуунаар нь хүйтэн юмыг хүйтнээр нь идэж байхаар анхаарна.

(Зажлах болон залгих чадварт тохирсон хоолны байдал)

"Жижиглэж хэрчсэн хоол: Хүнсийг идэхэд хялбархан байдлаар жижиглэсэн зүйл
Нухсан хоол: Хүнсийг нухаж боловсруулсан зүйл"
Зөөлөн хоол: Хүнсний хэлбэр дүрсийг хэвээр нь зөөлрүүлсэн зүйл
Зутан хоол: Зажлах чадвар алдагдсан хүн усанд хийж хахахгүй байхаар зутагнаж хийсэн зүйл

1) Хооллох байдал

⦿ Зөв хооллох байдал

Сандалд бөгсөө гүн суулгаж, хөлийн улыг шаланд хүргэнэ. Бага зэрэг урагш түрж суун, эрүүг бага зэрэг доошлуулсан байдалтай болгоно.



Орон дээр хооллох байдал

Суугаа байрлалд хооллох нь хүндрэлтэй байх тохиолдолд орон дээр хоол идэх тохиолдол байдаг.



- Орны түшлэгийг өргөж, цээжин биеийг босгосон байдалтай болгоно.
- Босгож дээшлүүлсний дараагаар биеийг матрааснаас хөндийрүүлж буцаан нуруу амраана.
- Цээжин биеийг босгосон байдалтай болгох нь хүндрэлтэй байвал хажуугаар хэвтэх байрлалтай болгоно.



Тал саажилттай байх тохиолдолд эрүүл талыг доод талд нь оруулна.

Хооллоход ашиглах хэрэгсэл



Барихад хялбар халбага, сэрээ



Холбогчтой савх

Барихад хялбар аяга



Тахир халбага, сэрээ



Ханцуйн бүстэй халбаганы гэр

Суурьтай сэнжтэй аяга



Утгахад хялбар таваг



Гулсахаас сэргийлсэн зөөлөвч

2) Хооллох асаргааны үед

(1) Асруулагчийн биеийн байдлыг шалгана.

(2) Асруулагчид хийх гэж байгаа зүйлийн зорилго болон тайлбарыг хийж зөвшөөрөл авна.

(3) Асруулагчийн гарыг цэвэрлэнэ.

(4) Хоолны ширээнд очиж, сандалд сууна.

Асрагч нь өвчний эмчилгээ болон харшил зэргийн улмаас идэж болохгүй зүйл байгаа эсэхийг урьдчилан шалгана.

(5) Хоолыг асруулагчийн өөдөөс, харагдах байрлалтайгаар тавина.

(6) Асрагч нь асруулагчийн зөв гар талд, эсвэл эрүүл талын хажууд асруулагч уруу харж сууна.

Асрагчийн байрлал

(7) Цэсийг (меню) тайлбарлана.

(8) Хоолны хамгийн эхэнд цай, шөл зэрэг шингэн зүйл уулгана.

Амны хөндийг чийгшүүлнэ.

(9) Асруулагчийн хоолны түвшинд тааруулан хооллох асаргааг хийнэ.

- Асрагч нь асруулагчтай ижил харааны түвшинд байхаар сууж асаргааг хийнэ.
- Нэг удаагийн халбагадах хэмжээний хоолыг зажлах хурдыг асруулагчаас асууж, ажиглангаа тохируулна.
- Саажилттай байх тохиолдолд амны эрүүл талаас хоол өгөх байдлаар хооллоно.
- Буруу хоолойгоор орохоос сэргийлэн зажилж байгаа үед нь ярихгүй байна.
- Эрүүг доошлуулсан байдлаар зажилж байгаа эсэхийг шалгана.
- Халбагаар асаргаа хийх үед халбагыг хэвтээ байрлалд байхаар хооллоно.

Зогсоогоор асаргаа хийвэл асруулагчийн эрүү нь дээшилж хоолоо буруу хоолойгоор оруулах эрсдэлтэй.



Халбагыг дээш эргүүлбэл хүзүү нь дээшлэх учраас тэр.

(10) Хоол нь дууссан эсэхийг асруулагчаас тодруулна.

(11) Аманд нь хоол үлдсэн эсэхийг шалгана.

(12) Амны хөндийн арчилгаа (зайлах, шүд угаах, хиймэл шүд цэвэрлэх) хийнэ.

(13) Хоол идсэний дараа 30 минут орчим буруу залгихаас үүдэлтэй уушгины үрэвсэл үүсэхээс сэргийлэн суугаа байрлалд байлгана.

3) Хооллох асаргааны анхаарах зүйлс

- Хооллох түвшин, байдал, хоол идэхэд асуудал байгаа эсэх, зажлах болон залгих байдал зэргийг ажиглана.
- Асруулагчийн хүсэлтэд нийцүүлэн хоолыг аманд байхаар тооцно.
- Харааны бэрхшээлтэй хүн байгаа тохиолдолд цагийн байршил (цагийн зүүний байршлаар мэдээлэх арга) ашиглана.

  Хоолны халуун хүйтэн, амталгаа зэргийг ч тайлбарлана.

Цагийн байршлын жишээ



6 цагийн байрлалд савх байна.

3 Бие засах асаргаа

1 Бие засахын ач холбогдол

Бие засах нь биеийн доторх хэрэгцээгүй зүйлийг биеэс гадагшлуулах явдал юм. Хэрэгцээгүй болсон зүйлд шээс, өтгөн, хөлс, нүүрстөрөгчийн давхар исэл зэрэг байдаг.

Бие засах нь эрүүл байхын тулд хүний биед шаардлагатай бүтэц юм. Мөн ялгаруулсан шээс, өтгөн нь эрүүл мэндийн байдлыг илэрхийлж байдаг. Бие засах асаргаа нь шаардлагатай учир шалтгаанд нийцүүлэн асрах нь чухал юм.

Бие засах нь ичих сэдэл төрүүлэх үйлдэл юм. Бие засах асаргаанд асруулагчийн сэтгэлийг ойлгож дэмжлэг үзүүлэх нь чухал.

2 Бие засах бүтэц

1) Шээх бүтэц

Шээс нь бөөрөнд бий болж, давсагт хуримтлагдсаны дараа шээсний сүвээр гадагшилдаг. Үүнийг шээх гэж хэлнэ.

Давсагт шээс нь 200-300мл хуримтлагдахад “Ариун цэврийн өрөө ормоор” санагддаг. Үүнийг шээс хүрэлт гэнэ.

Шээс бий болохтой холбоотой биеийн эрхтэн



2) Баах бүтэц

Амаар идсэн хоол болон ус нь ходоодонд очиж, боловсруулалт эхэлдэг. Хоол болон усыг нарийн гэдсэнд хүргэж, шим тэжээл болон усыг шингээж авдаг. Шингээсний дараах зүйл нь баас болж биеэс гадагшилдаг. Үүнийг баах гэж хэлнэ. Гэдсэнд баас хуримтлагдвал “Ариун цэврийн өрөө ормоор” санагдана. Үүнийг баас хүрэх гэнэ.

Баас хүрэх нь цаг хугацаа өнгөрөхөөр байхгүй болдог.

Баас бий болохтой холбоотой биеийн эрхтэн



Баах байдал

Урагш тонгойсон байдалтай болж, өсгийг өргөхөд баасны гарах нүх болон шулуун гэдэснээс анус хүртэл эгц шулуун болж, баас гарахдаа хялбар болно.

3 Шээс болон баасны хэлбэр, хэмжээ

1) Шээсний байдал

Шээсний хэмжээ болон давтамж нь орчин болон өвчний нөлөөнөөс өөрчлөгддөг.

Хэвийн шээс болон хэвийн бус шээс

		Хэвийн шээс	Хэвийн бус шээс
Шээс	Хэмжээ	1 өдөрт 1000-1500мл	1 өдөрт 2000-3000мл-с их (шээс ихсэх) 300-500мл хүртэл (шээс багасах)
	Давтамж	1 өдөрт 4-6 удаа	10 олон удаа (шээс ойртох)
	Үнэр	Үнэргүй	Аммиакийн хүчтэй үнэр
	Өнгө	Бүдэг шараас өнгөгүй	Тунадастай, өтгөн хүрэн, улаан өнгөтэй байх зэрэг

2) Баасны байдал

Баас нь идсэн зүйл болон өвчин зэргийн нөлөөнөөс өөрчлөгддөг. Тиймээс тухайн үеийн байдлаас хамааран хэлбэр болон өнгө, давтамж нь өөрчлөгддөг.

Асаргаа хийх үеийн хэвийн баасны байдлыг мэдэж авцгаая.

Хэвийн баас болон хэвийн бус баас

		Хэвийн баас	Хэвийн бус баас
Баас	Давтамж	1 өдөр 1-2 удаа	Бага бол (өтгөн хатах)
	Өнгө	Бор хүрэн өнгөтэй	Улаан, хар, цагаан зэрэг

4 Бие засах асаргааны хэрэглэл

Бие засахад төрөл бүрийн хэрэглэл байдаг. Багаж хэрэглэлийг нь тухайн хүний төлөв байдалд нь тохируулан ашиглана.

Төрөл бүрийн бие засах хэрэглэл

Багаж хэрэглэл	Хэлбэр төрх	Ашиглах хүн
Зөөврийн суултуур		Шээс ба баас хүрч байгаа ариун цэврийн өрөө хүртэл явж чадахгүй хүн болон шөнө дунд бие засах зэрэгт ашиглана.
Шээлтүүр ба хөтөвч		Шээс ба баас хүрч байгаа боловч хэвтэрт байгаа хүн болон биеийн байдал муу байгаа, суугаа байрлалд байх боломжгүй хүн ашиглана.
Живх, дэвсдэг живх		Шээс болон баас гарч байгааг мэдэхгүй тохиолдолд (шээс задгайрах ба мэдээгүй баах) болон ариун цэврийн өрөө, зөөврийн суултуур зэрэгт бие засах хүндрэлтэй хүн ашиглана.

5 Үйл ажиллагааны алдагдал, эмгэг нь бие засахад нөлөөлөх нь (шээс задгайрах, өтгөн хатах, гүйлгэх)

1) Шээс задгайрах

Шээс задгайрах гэдэг нь шээс өөрийн санаа бодлоос үл хамааран ялгаран алдах явдлыг хэлнэ.

●Шээс задгайрлын төрөл

	Нөхцөл байдал
Даралтат шээс задгайрал	Ханиалга, найтаах зэрэг гэдсэнд даралт үүссэн үед шээс гоожуулна.
Гэнэтийн шээс задгайрал	Шээс хүрэх боловч ариун цэврийн өрөө хүртэл тэсэж чадалгүй гоожуулна.
Ургент шинж тэмдгээр илрэх шээс задгайрал	Түрүү булчирхайн томролт зэрэг шээс дамжих суваг хаагдаж, шээс бага багаар алдана.
Рефлексийн шинжийн шээс задгайрал	Нугасны гэмтэл зэргээр шээс хүрэхгүйгээр шээс гоожуулна.
Үйл ажиллагааны шээс задгайрал	Шээж амжилгүй гоожуулна. Тэнэгрэл зэргийн улмаас ариун цэврийн өрөө мэдэлгүй амжилгүй гоожуулна.

2) Өтгөн хаталт

Өтгөн хаталт гэдэг нь энгийн үетэй харьцуулахад баах тоо болон хэмжээ нь буурсан байдалтай үргэлжлэхийг хэлнэ.

●Өтгөн хаталтын төрөл

	Нөхцөл байдал
Үйл ажиллагааны өтгөн хаталт	Биеийн үйл ажиллагааны улмаас бий болох өтгөн хаталт
Эмгэг жамын өтгөн хаталт	Хавдар болон үрэвсэл зэрэгтэй бөгөөд баас дамжих зам нь хаагдсанаас үүдэх өтгөн хаталт

Гол асаргаа

- Тогтмол бие засах дадал хэвшүүлэх.
- Шингэн авах хэмжээг сайтар хангах.
- Хоолонд хүнсний эслэг ихээр оруулах.
- Амьдралын явцад дасгал хөдөлгөөн хийх.

Өтгөн хаталт сайжрахгүй бол эмчид мэдэгдэнэ.

3) Гүйлгэх

Гүйлгэх гэдэг нь баасан дунд шингэн ихээр агуулагдах шингэн баасыг хэлнэ.

Гол асаргаа

- Шингэн ихээр гарах тул шингэн алдагдлаас сэргийлнэ.
- Амаар уух боломжтой бол буцалсан ус болон тасалгааны температурын хросол уулгана.
- Чацга нь анусны ойр орчмын арьсыг цочроох тул угаах зэргээр цэвэрлэнэ.

Цочмог гүйлгэлт нь халдварт өвчин байх сэжигтэй тул эмчид мэдэгдэнэ.

Бие засахад сэтгэл санааны стресс нөлөөлдөг тул асруулагчийн байдал болон гомдлыг сайн сонсоно. Асрагч нь бие зассаны дараах шээс болон баасны байдлыг сайтар ажиглана.

Бие хэвийн бус байгаа мэт ажиглагдвал шууд эмчид мэдэгдэнэ. Энэ нь асруулагчийн эрүүл мэндийг хамгаалж буй хэрэг юм.

6 Бие засах үйлдлийн процесс

Энгийн бие засах үйлдэлд олон үйлдэл агуулагдаж байдаг. Бие засах үйлдэл нь хүнд төвөгтэй мэдрэлийн ажиллагаа болон биеийн хөдөлгөөнтэй холбоотой байдаг.

Бие засах үйлдлийн процесс



(1) Шээс хүрэх, баас хүрэх мэдрэмж

(2) Ариун цэврийн өрөө явах

(3) Өмдөө шувтлах

(4) Бие засах бэлтгэл

(5) Бие засах

(6) Цэвэрлэх

(7) Өмдөө татах

(8) Ариун цэврийн өрөөнөөс гарах

Бие засахад асаргаа шаардлагатай асруулагч нь сэтгэлийн дарамт ихтэй байдаг. Хүндэтгэн хамгаалж байгаа эсэхийг шалгаж асаргаа хийх шаардлагатай.

7 Бие засах асаргааны үед

⦿ Бие засах асаргаанд анхаарах зүйлс

- Асруулагчийн бие засах дадлыг хамгаалах.
- Ичих сэдэл үүсэхэд анхаарах.
- Үнэрт анхаарах
- Тохирох бие засах арга, багаж хэрэглэл сонгоно.
- Асрагч нэг удаагийн бээлийн болон хормогч ашиглан халдвараас сэргийлнэ.

Бие засах орчны жишээ

L хэлбэрийн бариул
Босох үед ашиглана.

Хөдөлгөөнт бариул
Дээш доош хөдлөх тул асруулагчийн байдалд тааруулан ашиглана.



Дуудах товч
Хүнд байдалд орсон үед болон бие засаад дууссан үед асрагчийг дуудах боломжтой.

Гүйдэг хаалга
Тэргэнцэртэй асруулагч ч өөрөө нээж хааж болно.

1) Бие засах асаргааны үед ариун цэврийн өрөөний асаргаа

Энд зүүн тал саажилттай асруулагчаар жишээ аван тайлбарлав.

(1) Асруулагчийг ариун цэврийн өрөө хүртэл чиглүүлнэ.



(2) Асруулагчийн эрүүл талаар нь бариулаас бариулна.

(3) Асрагч нь өвтэй талд байрлаж, өмд болон дотуур хувцсыг нь шувтална.

(4) Асруулагч нь бариулаас барингаа суултуурт сууна.

Тогтвортой суугаа байрлалд орсон эсэхийг шалгана.

(5) Асрагч нь ариун цэврийн өрөөнөөс гарч хаалгыг хаана.

(6) Асруулагчаас дууссан гэх дохио ирвэл ариун цэврийн өрөөнд орно.

(7) Асруулагчийн дотуур хувцас болон өмдийг татах хэмжээнд хүртэл нь татна.

Суугаа байрлалаас татвал босоо байрлалд орсон үеийн ачаалал буурна.

(8) Асруулагч бариулаас барингаа дээш босно.





(9) Асруулагчийн босоо байрлал нь тогтвортой байдалд байгаа мэт бол өөрөөр нь дотуур хувцас болон өмдийг нь татуулна.

(10) Дотуур хувцас болон өмдийг хангалттай татсан эсэхийг шалгана.

2) Шээлтүүр ба хөтөвчийн асаргаа

(1) Хэрэгцээт зүйлсийг бэлдэнэ.

(2) Хөшиг хийж, нууцлалыг хамгаална.

(3) Орыг асрагчид тохирсон өндөртэй болгоно. Ус нэвтрүүлдэггүй дэвсгэр дэвсэнэ.

(4) Асруулагчийн өвгийг өргөж, бөгсийг өргөн өмд, дотуур хувцсыг шувтална.

(5) Бөгсийг өргөн анус нь хөтөвчийн яг голд байхаар тааруулан, тогтвортой байгаа эсэхийг шалгана.

Хэвлийд алчуур нөмөргөж нууцлалыг хамгаална.

Орны түшлэгийг өргөхөд гэдсэнд даралт үзүүлэх нь сайжирна.

(6) Бөгсийг өргөж бохирдсон хэсгийг цэвэрлэж, хөтөвчийг авна.

(7) Арьсыг ажиглана.

(8) Асруулагчийг хажуугаар хэвтэх байрлалд оруулж, ус нэвтэрдэггүй дэвсгэрийг авна.

(9) Дотуур хувцас болон өмдийг татаж, хувцсыг янзална.

(10) Орны өндрийг буцаана.

(11) Биеийн байдлыг шалгана.

(12) Эд зүйлийг цэвэрлэнэ.

Шээлтүүр ашиглаж бие засах

Эрэгтэй	Эмэгтэй
Хажуугаар хэвтэх байрлалд оруулж, нуруунд дэр зэргийг ивж, шээлтүүрийг углана.	Шээс үсэрч асгарахгүй байхаар сальфетка зэрэгт шээсийг арчина.
	

3) Живх солих асаргаа

(1) Асруулагчийн биеийн байдлыг шалгана.

(2) Асруулагчид хийх гэж байгаа зүйлийн зорилго болон тайлбарыг хийж зөвшөөрөл авна.

(3) Хэрэгцээт зүйлсийг бэлдэнэ.

(4) Орыг асрагчид тохирсон өндөртэй болгоно.

(5) Асруулагчийг хажуугаар хэвтэх байрлалд оруулж, ус нэвтэрдэггүй дэвсгэрийг дэвсэнэ.

(6) Дээш харж хэвтэх байрлалд буцааж, бөгсийг өргөн өмдийг шувтална.

(7) Живхний наалтыг салгана.

(8) Шүршигч саванд хийсэн бүлээн усаар хярзан хавийг угаана.

Эмэгтэй хүн байх тохиолдолд шээсний сүвнээс анус чиглэлд (өөрөөр хэлбэл урдаас арагш чигт) угааж арчина (халдвараас сэргийлэх). Арьс давхардсан хэсгийг ч сайтар угаана.

Бүлээн ус нь биеийн дулаантай ойролцоо байх (Хярзан нь температурт мэдрэмтгий байдаг.).

(9) Хуурай алчуураар усыг арчина.

(10) Бохирдсон живхийг бөөрөнхийлөн, хажуугаар хэвтэх байрлалд оруулна.



Бохирдсон хэсгийг
дотор талд нь оруулна.

(11) Шинэ живхийг бохирдсон живхний доор хийнэ. Дээш харж хэвтэх байрлалд буцаан эсрэг талаас бохирдсон живхийг авна. Бохирдсон живхийг хаясны дараа бээлийг тайлна.



(12) Хэвлий ба гуяны хэсэгт 2 - 3 хуруу чөлөөтэй орж байхаар наалтыг наана.

Чанга бариу байх нь загатнуулах шалтгаан болдог.

(13) Бөгсийг өргөн өмдийг татна. Хувцас болон дэвсгэрийг янзална.



Хувцас болон дэвсгэр нь үрчлээтэй байвал тухгүй бөгөөд цооролтыг бий болгоно.

(14) Өрөөний агаарыг сэлгэнэ.

(15) Биеийн байдлыг шалгана.

(16) Эд зүйлийг цэвэрлэнэ.

4 Бие арчлах асаргаа

1 Бие арчлахын ач холбогдол

Бие арчлах нь нүүрээ угаах, үсээ самнах, хувцас солих зэрэг биеэ цэгцлэх явдал юм. Бие арчлах нь биеийн ариун цэврийг хангах төдий бус өөрийгөө илэрхийлэх зүйл бөгөөд сэтгэл санааны бие даахтай холбоотой. Мөн нийгэм дэх бусад хүнтэй харилцах харилцааг бий болгох чухал үйлдэл юм.

2 Бие арчлахтай холбоотой бие болон сэтгэлийн бүтэц

Бие арчлах нь өөрийгөө илэрхийлэх аргын нэг юм. Тухайн хүний амьдралын дадал хэвшил болон үнэт зүйлийг хүндэтгэн асрах шаардлагатай. Бие арчлах дэмжлэг гэдэг нь амьдрах хүсэл эрмэлзлийг өдөөн гаргах явдал байдаг.

(Бие арчлахын үр дүн)

(1) Биеийн дулааныг тохируулах, арьсыг хамгаална.
(2) Сэтгэл зүрхний үйл ажиллагааг хангах, сайжруулна.
(3) Аюулгүй бөгөөд тухтай амьдрах боломжтой болно.
(4) Амьдралыг баян болгоно.
(5) Өөрийгөө илэрхийлэх боломжтой болно.

⦿ Бие арчлах асаргаанд анхаарах зүйлс

- Амьдралын дадал хэвшил болон дуртай зүйл зэргийг тухайн хүний өөрийн сонголтыг хүндэлнэ.
- Улирал болон тухайн өдрийн үйл ажиллагаа зэрэгт тохирсон дэмжлэг үзүүлнэ.
- Бие сэтгэлийн нөхцөл байдалд тааруулна.

● Улиралд тохирсон хувцаслалт

Зун



Өвөл



3 Хувцас өмсөж тайлах асаргааны үед

⦿ Хувцас өмсөх тайлах асаргааны анхаарах зүйлс

